

ҮАГ

ҮАГ-ын 2015 оны аудитын төлөвлөгөөний
дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2015 оны 3 дугаар сар

**Үндсэн чиглэлийн зорилтын
хэрэгжилт, үр дүнд тавих
хяналт сул байна**

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд
хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүн





МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Аудитыг гүйцэтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор:
С.Төмөрхүү

Чиглэлийн аудитын албаны менежер: Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор Ж.Эрдэнэ
Р.Гончигцэрэн

Чиглэлийн аудитын албаны аудитор, шинжээчид
Л.Авирмэд
Ж.Оюунтуяа
Ш.Наранбаатар
Б.Буянхишиг

ҮАГ-ын харьяа аймаг, нийслэлийн аудитын газрын болон ГАГ-ын Төсвийн гүйцэтгэл, Хөрөнгө оруулалтын албаны аудитор, шинжээч нар

Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 263755, 262451, 261805 дугаарын утсаар харилцана уу.
Аудитын тайланг ҮАГ-ын сайтаас үзнэ үү. www.audit.mn

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160
МОНГОЛ УЛС

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5

Аудитын хураангуй

▪ Оршил	7
▪ Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал	7
▪ Сайжруулах асуудал	7

Бүлэг 1. Үндсэн чиглэлийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад ахиц өөрчлөлт гараагүй байна

▪ Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт гараагүй байна	8
▪ Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр нь зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй байна	9
▪ Зорилт, арга хэмжээг судалгаа тооцоонд үндэслэн бодитой төлөвлөхгүй байна	10

Бүлэг 2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил бодитой үр дүнд хүрээгүй байна

▪ Зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ дутагдалтайгаас 37.8 хувь нь хэрэгжээгүй байна	12
▪ Макро эдийн засгийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн хүрэх түвшний үзүүлэлт хангагдаагүй байна	12
▪ Бодит салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө бага төлөвлөгдөж хэрэгжилт 68.0 хувьтай байна	12
▪ Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн зорилтоос “Ногоон хөгжлийн асуудал” хэрэгжилт хангалтгүй байна	14

Агуулга

- Үргэлжлэл -

- Нийгмийн хөгжлийн бодлогын 36 зорилт, арга хэмжээий биелэлт 65.0 хувьтай хэрэгжсэн байна 15
- Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн зорилт 67.0 хувьтай хэрэгжсэн байна 16
- Гадаад бодлого, батлан хамгаалахын зорилт, арга хэмжээ 58.0 хувьтай хэрэгжсэн байна 16

Бүлэг 3. ТЕЗ-дын үндсэн чиглэлийн биелэлт, гүйцэтгэлийн тайлагнал үр нөлөөтэй болоогүй байна

- Хэрэгжилт, тайлагнал, үнэлгээний тогтолцоог шинэ түвшинд гаргах шаардлагатай 21
- Үндсэн чиглэлийн хэрэгжилттэй холбогдуулан гарсан шийдвэрийн биелэлт хангалтгүй байна 22

Аудит дүгнэлт 23

Аудитын зөвлөмж 24

Холбогдох байгууллагын санал:

Нэг. Сангийн яамнаас ирүүлсэн санал 25

Саналд өгсөн тайлбар: 26

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ 27

ХАВСРАЛТУУД:

Хавсралт А. “Үндсэн чиглэлийн хэрэгжсэн зорилт, арга хэмжээний жагсаалт” 28

Хавсралт Б. “Үндсэн чиглэлийн хэрэгжилт дутуу зорилт, арга хэмжээний жагсаалт” 30

Хавсралт В. “Үндсэн чиглэлийн “0-10” хувийн биелэлттэй зорилт, арга хэмжээний жагсаалт” 33

Хавсралт Г. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөв байдлын судалгаа 34

Товчилсон үгийн жагсаалт

АНАГ	Аймаг, нийслэлийн аудитын газар
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГУАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗТЯ	Зам, тээврийн яам
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
УУЯ	Уул уурхайн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ҮХЦБ	“Үндэсний хөгжлийн цогц бодлого”
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМСЯ	Эрүүл мэнд, спортын яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2015 онд нийлүүлэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдлыг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Үндсэн чиглэлийн арга хэмжээ оновчтой төлөвлөгдсөн эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг хангахуйц үр нөлөөтэй ажлыг зохион байгуулсан эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд биелэлт, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж, үр дүнг тооцсон эсэх.

Хамарсан хүрээ

Улсын Их Хурлын 2013 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх болон биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн ажлын албадыг хамруулан гүйцэтгэв.

Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг тэдгээрийн гаргасан тайлагналд үндэслэн ҮАГ-ын харьяа аймаг, нийслэл дэх аудитын газрууд тодруулга, судалгаа ирүүлсэн болно.

Арга зүй стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан биелэлтийн тайланд судалгаа хийж үнэлэх,
- Хөрөнгийн эх үүсвэрийн уялдааг судлах, гүйцэтгэлийг харьцуулах,
- Холбогдох төрийн байгууллагын албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судлах,
- Яамдын хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлсэн дотоод аудитын нэгжийн үнэлгээ, тайланг судлах, ҮАГ-аас 2013 онд хийсэн аудитын дүгнэлт, өгсөн зөвлөмж, санал асуулгын дүнг нягтлах, харьцуулалт хийх, нөхцөл байдлыг үнэлэх,
- ТЕЗ бүрээр аудитын урьдчилсан тайланг бэлтгэж, хэрэгжилтийн байдлыг танилцуулах,

- Санхүү төсвийн асуудал болон хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан төрийн байгууллагуудаас гаргасан улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, төрөөс баримтлах урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт материалд тулгуурлан судалгаа хийх,
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн нотлох зүйлстэй тулган шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах,
- Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг тэдгээрийн гаргасан тайлагналд үндэслэн ҮАГ-ын харьяа аймаг, нийслэл дэх аудитын газрууд батлагдсан хөтөлбөр, аудитын арга зүй, горимын дагуу нотлох зүйлс цуглуулан судалгаа гарган, тодруулга хийх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орж ЭЗХЯ татан буугдсантай холбоотойгоор ТЕЗ-дын хариуцах арга хэмжээг шинээр байгуулагдсан яамдад шилжүүлэх, тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэх ажил удааширсан байна.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль, 2004 оны 2 дугаар тогтоолын дагуу Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг жил бүрийн эхний улиралд УИХ-д танилцуулахаар журамласан нь аудитыг гүйцэтгэх, нэгдсэн дүгнэлт гаргахад төлөвлөгөөт хугацаанд багагүй нөлөөлж байгаа бөгөөд мөн оны төсвийн болон хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, улсын нэгдсэн статистик дүн мэдээ эцэслэн гараагүй нь цаг хугацааны хувьд бодитой үнэлгээ, дүгнэлт гаргахад сөргөөр нөлөөлж байна.

Аудитын хураангуй

Оршил

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулсан бөгөөд түүний үндэслэл, хүчин зүйлсийн нөлөөлөл, оршин буй нөхцөл байдлын талаарх дүнг холбогдох дарааллаар тайлангийн I, II, III бүлэгт харуулав.

Засгийн газраас улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хангуулах нэгдсэн төлөвлөгөө батлаагүй бөгөөд төрийн төв байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 104 арга хэмжээнд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан ҮХЦБ-оос 15, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 80 арга хэмжээ тусгагдсан байна.

Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд буюу ТЕЗ-дын гаргасан биелэлтийн дундаж “73.3” хувьтай, Сангийн яам “73.7” хувиар, ЗГХЭГ “63.7” хувиар тус тус үнэлсэн байна.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, арга зүйн дагуу хийсэн дүн шинжилгээ, үнэлгээний дүнгээр нийт 104 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 32, хэрэгжилт дутуу 62, хэрэгжээгүй 10 буюу биелэлт “63.2” хувьтай байна.

Сайжруулах асуудал

ЗГХЭГ, ТЕЗ-даас үндсэн чиглэлийн биелэлтийг хангахад гарч буй зардлын үр ашиг, үр дүнг тооцох арга зүйг боловсруулан ашиглах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил тодорхой үр дүнд хүрээгүй, зарчмын өөрчлөлт үгүйлэгдэж байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжих хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан төлөвлөөгүй, хэрэгжилт биелэлтэд ТЕЗ-дын шуурхай удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг, эрх зүйн шинэчлэлийн арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.

Эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар ТЕЗ-даас зохион байгуулж, үр дүнд хүрсэн ажил хангалтгүй байгаа нь асуудлыг шийдвэрлэх талаар санаачлага дутагдаж байгааг харуулж байна.

Бүлэг 1. Үндсэн чиглэлийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад ахиц өөрчлөлт гараагүй байна

1.1 Үндсэн чиглэлийн төлөвлөлт, түүнийг боловсруулахад хууль тогтоомжийн шаардлагыг баримтлан хэрэгжих үндэслэл, үр дүнг урьдчилан тооцсон, хамрах хүрээг оновчтой төлөвлөсөн, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур, хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоолол бодитой эсэхэд тулгуурлав.

1.2 Үндсэн чиглэлийн нийт 104 арга хэмжээний шалгуур үзүүлэлт хүрэх түвшинд хийсэн судалгаагаар үзэхэд 44 буюу 42.3 хувийг “үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар” үнэлэхээр, 49 арга хэмжээ буюу 47.1 хувь нь хөрөнгийн эх үүсвэргүй төлөвлөгдсөн нь биелэлтийг тооцоход тодорхойгүй шалгуур хэрэглэсэн, харьцуулалт хийхэд хүндрэлтэй, суурь үзүүлэлтийн тооцоо судалгаагүй төлөвлөгджээ.

1.3 Уул уурхай, Эрүүл мэнд, спорт, Хууль зүй зэрэг салбарын зорилт, арга хэмжээний дийлэнх нь үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар үнэлэгдэхээр төлөвлөгдсөн байна. Жишээлбэл: Эрчим хүчний салбарт “Гэр хорооллын цахилгаан хангамжийг найдвартай болгох” зорилтын 2014 онд хүрэх түвшинг тодорхойлохдоо Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийн 4 жилд хэрэгжүүлэх зорилтыг бүтнээр тавьсан байна.

1.4 УИХ-ын 39 дүгээр тогтоолоор баталсан улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 6 бодлогын хүрээний нийт 25 зорилт, 104 арга хэмжээ тусгагджээ¹.

1.5 Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээний тоо 2014 онд буурсан ч нийгмийн хөгжлийн бодлогын хүрээний асуудалд ач холбогдол өгсөн байна.

Бодлогын хамрах хүрээ	Хүснэгт №1.1 УИХ-ын 2013 оны 39 дүгээр тогтоол	
	Зорилт	Арга хэмжээ
I. Макро эдийн засгийн бодлого	1	11
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	8	28
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	3	10
IV. Нийгмийн хөгжлийн бодлого	9	36
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэл	2	10
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	2	9
Нийт	25	104

Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт гараагүй байна

1.6 УИХ-аас үндсэн чиглэлийг батлахдаа “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-той уялдуулан Засгийн газраас хэрэгжилтийг оны эхнээс хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг даалгасан байна².

1.7 Засгийн газраас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийг ТЕЗ-даас хагас бүтэн жилээр гаргуулж ажилласан ч үр дүн, үр нөлөөт байдлын үнэлгээний ажил, хэрэгжүүлэх талаар зохиосон ажил хангалттай бус, саналыг авч, нэгтгэн дүгнэсэн, урьдчилсан тооцоо судалгаа хийсэн гэх баримт Сангийн яам, ЗГХЭГ-т алга байна.

¹Улсын Их Хурлын 2004 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын 1.2-т “... үндсэн чиглэл нь Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн стратеги, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах бодлогын баримт бичиг болохыг заасан.

²Эх сурвалж: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр тогтоол

1.8 Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт ороогүй, төлөвлөлт, судалгаа, тооцооллын үндэслэлийг сайжруулах талаар өмнөх жилүүдтэй харьцуулахад дорвитой ахиц дэвшил ажиглагдахгүй байна.

1.9 Үндсэн чиглэлд туссан макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдэд хэрхэн төлөвлөж байсныг авч үзвэл:

Хүснэгт №1.2

Зорилт, арга хэмжээний төлөвлөлт	Хүрэх түвшин /оноор/			
	2011	2012	2013	2014
ДНБ-ий бодит өсөлт /%-уар/	8.2	16.6	19.0	14.7
Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ /ам.долл/	2076.5	3900.0	4930.0	5300.0
Инфляцийн түвшин /%-уар/	9.7	9.0	8.0	6.0
ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх хувь	35.4	29.8	39.2	32.1
ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн зарлагын эзлэх хувь	40.4	36.5	41.2	33.9
ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	5.0	6.7	2.0	2.0

1.10 Макро эдийн засгийн төлөвлөсөн зарим үзүүлэлтийн хувьд 2014 онд ДНБ-ий бодит өсөлтийг 14.7 хувьд хүргэн, инфляцийн зорилтот түвшинг 6.0 хувьд байлгах, төсвийн алдагдлыг бууруулах зэргээр эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого, зарчмыг мөрдлөг болгохоор төлөвлөсөн байна.

Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр нь зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй байна

Хүснэгт №1.3

№	Эх үүсвэрийн ангилал	Үндсэн чиглэл /оноор/				тбм.төг
		2011	2012	2013	2014	
1	Улсын төсөв	357.8	1 964.5	2 108.6	362.5	
2	Гадаад эх үүсвэр	81.7	198.3	367.8	516.6	
3	Гадаадын хөрөнгө оруулалт	338.0	-	-	-	
4	ТХХТ	2 091.8	440.5	697.0	-	
5	Уул уурхайн орлого	513.0	-	-	-	
6	Хувийн хөрөнгө оруулалт	-	952.2	615.7	4.0	
7	Орон нутгийн төсөв	-	2.8	-	-	
8	Хүний хөгжил сан	-	23.0	-	-	
9	Гадаадын зээл, тусламж	183.7	-	-	-	
10	Тусгай сан, бусад эх үүсвэр	247.2	-	116.7	-	
	ДҮН	3 813.2	3 581.3	3 905.8	883.1	

1.12 Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад 3,022.7 тэрбум төгрөгөөр, түүний дотор улсын төсвийн эх үүсвэр 1,746.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь арга хэмжээний хэрэгжилтийг хангах хэмжээнд төлөвлөөгүй байна.

1.13 Үндсэн чиглэлийн 104 арга хэмжээнээс 47.2 хувьд буюу 49 арга хэмжээнд нийтдээ 883.1 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс улсын төсвөөс 45, гадаад эх үүсвэрээс 3, хувийн хэвшлийн хөрөнгөөр 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

1.14 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний эх үүсвэрт нийт 883.1 тэрбум төгрөг төлөвлөгдсөний 362.5 тэрбум төгрөг буюу 41.0 хувийг улсын төсвөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч зарим арга хэмжээнд хөрөнгө төлөвлөгдөөгүй байна.

1.15 Гэвч 2014 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр үндсэн чиглэлд тусгагдсан хөрөнгө оруулалтын шинжтэй 74.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 арга хэмжээнд 20.1 тэрбум төгрөг батлагдсан байна.

1.16 Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг санхүү, хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй төлөвлөлтийн алдаатай бодлоготой холбон тайлбарлаж байгаа боловч бусад нөөц, эх үүсвэрийг ашигласан талаар болон ямар нэг шийдэл, нөхцөл байдалтай уялдуулсан арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Зорилт, арга хэмжээг судалгаа тооцоонд үндэслэн бодитой төлөвлөхгүй байна

1.17 ТЕЗ-дын арга хэмжээний төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж үзвэл:

Хүснэгт №1.4

Бодлогын хамрах хүрээ	Арга хэмжээний тоо	Төлөвлөлтийн үндэслэл			
		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	Хөрөнгө, нөөцийг тооцоогүй	Шалгуур болон хүрэх түвшинг гаргаагүй	Бусад хөтөлбөр, салбарын бодлоготой уялдаагүй
I. Макро эдийн засгийн бодлого	11	11	1	-	2
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	28	10	7	1	1
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	10	1	1	-	-
IV. Нийгмийн хөгжлийн бодлого	36	13	2	1	4
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэл	10	5	-	1	1
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	9	4	-	-	-
Нийт	104	44	49	3	8

1.18 Бодит салбарын хөгжлийн бодлогын 28 арга хэмжээнээс 10 нь үйл ажиллагааны хэрэгжилтээр төлөвлөгдсөний дотор төсөв хөрөнгө шаардлагатай дараах арга хэмжээ байсан нь эдийн засагт өсөлт, үр ашгийг бий болгох салбарт хөрөнгө нөөц дутагдалтай төлөвлөгдсөнийг илтгэж байна. Жишээлбэл,

- 1.5-ын нийгмийн даатгалын санг мөнгөжүүлэх замаар ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх,
- 5.1-ийн геологийн албыг бэхжүүлж, геологийн судалгааг өргөжүүлэх,
- 5.2-ын эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих,
- 5.5-ын газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрийг барьж эхлэх,
- 5.6-ын эзэнгүй, эвдрэлтэй талбайг нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх,

- 5.8-ын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын шатахууны нөөц хадгалах агуулахыг байгуулах гэх мэт хөрөнгө шаардсан ажлууд байна.

1.19 ТЕЗ-даас зорилтот түвшин, харгалзах үзүүлэлт, үр дагаврын хамрах хүрээг ерөнхий байдлаар төлөвлөдөг дутагдал давтагдсаар байгаа нь төлөвлөлтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хүлээгдэж буй үр дүнг бодитой тооцох, байгууллагын ХШҮ-ний ажлын зохион байгуулалт хангалтгүйтэй холбоотой байна.

1.20 Үндсэн чиглэлд үйл ажиллагааны хэрэгжилт, явцаар төлөвлөгдөж буй он дамжин хэрэгжих зорилт, арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт тодорхойгүй нь эцсийн үр нөлөө, хэрэгжилт хангалтгүй, биелэлтийг бодитой үнэлэхэд бэрхшээлтэй байна.

Бүлэг 2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил бодитой үр дүнд хүрээгүй байна

Зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ дутагдалтайгаас 37.8 хувь нь хэрэгжээгүй байна

2.1. Яамд эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан асуудлыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан байна.

2.2. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 160 дугаар тушаалаар баталсан өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөн гэсэн шалтгаанаар ТЕЗ-даас гаргаж ирүүлээгүй бөгөөд ЗГХЭГ-аас энэ талаар ямар нэг зохицуулалт хийж нэгтгэн зохион байгуулаагүй байна.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн хүрэх түвшний үзүүлэлт хангагдаагүй байна

2.3 Сангийн яамны тайлагнаснаар макро эдийн засгийн бодлогын асуудал 65 хувьтай хэрэгжсэн бол аудитаар энэ хүрээнд тусгагдсан 9 зорилтоос бүрэн хэрэгжсэн 1, дутуу хэрэгжсэн 7, хэрэгжээгүй 2 арга хэмжээ 52 хувийн биелэлттэй байгаа нь эдийн засгийн гол үзүүлэлт буурсан, гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг татаж бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх, нүүрс, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний экспортын өсөлтийг хадгалахаар төлөвлөсөн боловч олон улсын зах зээл дээр голлох түүхий эдийн үнэ унаж, эдийн засагт хүндрэл гарсантай холбоотой байна.

2.4 Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 70 орчим хувиар буурснаас эдийн засгийн өсөлтийн хурдац төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

2.5 ЭЗХЯ /хуучин нэрээр/ дангаар болон хамтран хэрэгжүүлэх макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангаж эдийн засгийг эрчимжүүлэх чиглэлийн дараах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- 1.1-ийн эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ 50 хувьтай,
- 1.2-ын эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг бууруулах арга хэмжээ 50 хувьтай;
- 1.7-ийн гадаад худалдааны гол түнш улсуудтай тухайн улсын валютаар арилжаа хийх тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ 30 хувийн;
- 1.9-ийн үнэ, тарифын тухай хуулийг шинээр боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 50 хувийн;
- 1.11-ийн банк, санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Бодит салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө бага төлөвлөгдөж биелэлт 68.0 хувьтай байна

2.6 Бодит салбарын хөгжлийн бодлогын гол асуудлыг АҮЯ, БХБЯ, ЗТЯ, ЭХЯ, УУЯ, ХХААЯ хариуцан хэрэгжилт, биелэлтийг үнэлж байгаа бөгөөд хөрөнгө санхүүгийн эх үүсвэр шаардлагатай 28 арга хэмжээний 10-т нь тайлант онд хөрөнгийн ямар ч эх үүсвэр төлөвлөгдөөгүй нь гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

2.7 Бодит салбарт төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогыг эрчимжүүлэх, агаарын тээврийн салбарыг хөгжүүлэх, зам дэд бүтэц, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх, барилгын салбарт дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрлэл, ХАА-н салбарыг хөгжүүлэх, аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэргээр эдийн засгийн түлхүүр асуудлыг төлөвлөсөн ч биелэлт 68.0 хувьтай байна³.

2.8 Улс орны хөгжилд чухал үүрэгтэй Ухаа худаг-Гашуун сухайт, Чойбалсан-Бичигт, Ухаа худаг- Сайн шанд-Хөөт чиглэлд төмөр замын суурь дэд бүтцийг барих асуудалд улсын төсвөөс хөрөнгө тусгаагүй боловч Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны 88.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж эхэлсэн боловч гүйцэтгэл 40 гаруй хувьтай үргэлжилж байна.

2.9 Аймгийн төвүүдийг нийслэлтэй холбосон хатуу хучилттай 775.4 км авто зам барихаар төлөвлөж 2014 онд 500 км зам ашиглалтад оруулсан нь төлөвлөсөн үзүүлэлтийн 64.5 хувь болж байна. Өмнөх жилтэй харьцуулахад барьж ашиглалтад оруулсан зам 33.8 км-ээр бага байна.

2.10 Эрдэс баялгийн салбарт дэвшүүлсэн 9 арга хэмжээнд улсын төсвөөс ямар ч хөрөнгө төлөвлөөгүй бөгөөд стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, шатдаг занараас шатахуун гаргах үйлдвэр байгуулах зэрэг чухал ач холбогдолтой төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байгаа нь төрийн байгууллагуудын улс орны эдийн засаг, нийгмийн өмнө хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт удаашралтай, хяналт сулаас гүйцэтгэлд муугаар нөлөөлсөн байна. Бодит салбарт хэрэгжээгүй арга хэмжээний нөхцөл шалтгааныг тодруулбал:

- 8.1-д “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор барих ажил жил бүрийн үндсэн чиглэлд тусгагдаж байгаа ч ажлын явц хангалтгүй, дорвитой ахиц гараагүй, холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах бодлого хэрэгжүүлэх ажлын явц, хэрэгжилт удааширсан нь зураг төслийг магадлалаар оруулан хүлээгдэж байгаагаас шалтгаалсан,
- 8.4-т Био бордооны үйлдвэрийг хувийн хэвшилд тулгуурлан байгуулахаар төлөвлөж Хөгжлийн банкинд хэд хэдэн удаа төсөл хүргүүлсэн боловч зээл олгогдоогүйгээс үйлдвэр баригдаагүй нь хувийн хэвшлийн санаачлагад тулгуурласан бодлогын дэмжлэг үзүүлэх ажил хангалтгүй,
- 23.1-д заасан “Эрдэнэт, Дархан, Хархорин, Ховд, Улиастай, Зуунмод болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх” ажил барилга, хот байгуулалтын салбарт 2014 оны улсын төсвийн тухай хуульд хөрөнгө батлагдаагүйгээс хэрэгжээгүй,
- 5.7-д тусгагдсан газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрлэлийг барьж эхлэх ажилд хөрөнгө төлөвлөгдөөгүйн улмаас хэрэгжээгүй,
- 4.3-т тусгагдсан нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах хүрээнд тусгай замын автобусны дэд бүтцийн барилга барих ажил хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа, зохион байгуулалт муугаас хэрэгжээгүй байна.

³ Эх сурвалж: Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоол,
Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож, авто тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх тухай УИХ-ын мөн оны 36 дугаар тогтоол баталсан

2.11 Бодит салбарт дэвшүүлсэн томоохон зорилт, арга хэмжээний хэрэгжилт хурдац саарсан, үр өгөөж, үр дүн хангалттай биш байгаа нь уул уурхайгаас олох орлого, ашгийн үр дүн гараагүй, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа зэрэг хүчин зүйлээс шалтгаалж эдийн засгийн өндөр өсөлтийг хангах зорилтод сөргөөр нөлөөлжээ.

Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн зорилт, арга хэмжээнээс “Ногоон хөгжлийн асуудал” бүрэн хэрэгжээгүй байна

2.12 БОНХАЖЯ, НЗДТГ хариуцахаар үндсэн чиглэлд туссан 10 арга хэмжээнээс үндэсний байгаль, соёл, түүхийн өв газруудын хил хязгаарыг тогтоох судалгаа хийж зөвлөмж гарган ногоон хөгжил, ногоон эдийн засгийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийслэлийн гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах зэрэг арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн байна.

2.13 БОНХАЖЯ аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулан яамдаас санал авч төслийг хүргүүлсэн боловч Засгийн газраас буцаасан нь бодлогын баримт бичгийг үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотойгоор хугацаа алдаж байна.

2.14 Улсын тусгай хамгаалалтад зарим газрыг авах асуудал Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдсэн боловч Засгийн газрын зарим гишүүдийн саналаар тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байна. Үүнд:

1/ Ховд аймгийн Булган, Алтай сум, Говь-Алтай аймгийн Бугат сумын нутгийн зарим хэсгийг Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хилийн заагт хамруулан Зүүн гарын говь гэсэн нэр бүхий дархан цаазат газрын ангиллаар;

2/ Ховд аймгийн Булган сумын нутгийн зарим хэсгийг Булган голын эх-Их Онгогийн байгалийн цогцолборт газрын хилийн заагт, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутгийн зарим хэсгийг Дарьгангын байгалийн цогцолборт газрын хилийн заагт тус тус хамруулан байгалийн цогцолборт газрын ангиллаар;

3/ Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нуруу, Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Өлзийт сумдын нутгийг дамнан орших Дулаан хайрхан уулыг байгалийн нөөц газрын ангиллаар тусгай хамгаалалтад авах санал байв.

2.15 Нийслэлд орон нутгийн хөгжлийн сангийн 3,641.6 сая төгрөгийн хөрөнгөөр 15 байршлын 9.93 га талбайд сул шороон хөрсийг хайрган хучилттай болгох, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 3 байршлын 1.63 га талбайд тохижилт, ногоон байгууламж бүхий цэцэрлэг байгуулах 650.4 сая төгрөгийн өртөг бүхий ажил газрын асуудал шийдвэрлэгдээгүйгээс хэрэгжээгүй байна.

2.16 Гэр хорооллын айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулахад 2014 онд 10.0 мянган өрхийг төлөвлөснөөс 3198 айл өрхийг төвлөрсөн шугамд холбох төлөвлөлт, судалгааны ажил эхлэл төдий байна.

2.17 Энэ асуудлыг улсын төсвийн 6,800.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч улсын төсвөөс санхүүжилт аваагүй, харин нийслэлийн төсвөөс 9,441.6

сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 8,329.3 сая төгрөг зарцуулсан бөгөөд зорилт, арга хэмжээний биелэлт 69.8 хувьтай байна.

2.18 Байгаль орчин, бүс нутгийн салбарт дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хэрэгжилт 69.0 хувьтай байна.

Нийгмийн хөгжлийн бодлогын 36 зорилт, арга хэмжээний биелэлт 65.0 хувьтай байна

2.19 БСШУЯ, ХАХНХЯ, ХЯ, ЭМСЯ 9 зорилт, 36 арга хэмжээг хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд үндсэн чиглэлийн арга хэмжээний 34.6 хувийг нийгмийн салбарын асуудал эзэлж байна.

2.20 Гол асуудал нь “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд, нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэг рүү чиглүүлж, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, өрсөлдөх чадварыг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэн бүрт хүргэхэд чиглэгдэж, хүний хөгжлийн асуудал хэрхэн дэмжигдэх нь төлөвлөлтийн болоод хэрэгжилтийн шатандаа тодорхойгүй үлдэж байна.

2.21 Нийгмийн бодлогын салбарт дутуу ба хэрэгжээгүй дараах асуудлууд шийдлээ хүлээж байгаа бөгөөд биелэлтийн байдлыг авч үзвэл:

- 13.2-ын хот суурингаас хөдөө орон нутагт шилжин суурьших, ажил эрхлэх санаачилгыг зээл, санхүүгийн дэмжлэг урамшууллын бодлогоор дэмжих ажил 50 хувьтай; /Хөдөлмөрийн яам/
- 14.1-ийн эх /эцэг/ нь төрүүлсэн хүүхдээ хоёр нас хүртэл, ихэр хүүхдийг гурван нас хүртэл өөрөө асран хүмүүжүүлэх, тэтгэмж дэмжлэгийн эрх зүйн орчныг бүрдүүлэх ажил хийгдээгүй; /ХАХНХЯ/
- 15.1-ийн төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх ажил 50 хувьтай; /ХАХНХЯ/
- 19.9-ийн эм ханган нийлүүлэх тогтолцоог бэхжүүлэх ажил 30 хувьтай; /ЭМСЯ/
- 19.8-ын эмийн аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх асуудал 30 хувьтай; /ЭМСЯ/
- 21.1-ийн багийн спортыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажил хэрэгжээгүй; /ЭМСЯ/
- 21.2-ын аймаг, нийслэл, сум, дүүрэгт явган аялах чиглэл тогтоож, хөгжүүлэх ажил 10 хувьтай; /ЭМСЯ/
- 21.3-ын хүн амыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх ажил хэрэгжээгүй; /ЭМСЯ/
- 16.3-ын цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ажлын ачааллыг багасгах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж, 2500 ээлжийн болон туслах багш бэлтгэх арга хэмжээ ажил 10 хувьтай; /БСШУЯ/
- 17.2-ын хүүхэд бүрд ном уншуулах эрмэлзэл төрүүлэх, унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх Цахим сургалтын үндэсний 2 төв байгуулах ажил 30 хувьтай; /БСШУЯ/
- 18.1-ийн монгол судлалын сан байгуулж үйл ажиллагааг нь төрөөс дэмжих арга хэмжээ хэрэгжүүлсэн төсөл, бэлтгэсэн судлаачийн тоо дэвшүүлсэн зорилтод хүрээгүй 30 хувийн биелэлттэй байна. /БСШУЯ/

2.22 Эрүүл мэнд, спортын салбараас биеийн тамир, спортын талаар үндсэн чиглэлд тусгагдсан 3 арга хэмжээ хэрэгжээгүй нь хөтөлбөр боловсруулах, аяллын чиглэл

тогтоох, хүн амыг чийрэгжүүлэх зэрэг хөрөнгө мөнгө ихээхэн шаардлагатай бус харин удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаагаар хэрэгжих асуудлууд байсан байна. 2.23 Хөдөлмөрийн салбарт түр ажилтныг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг, урамшуулал үзүүлэх арга хэмжээ төлөвлөгдсөн хэмжээнээс бага хувьтай биелжээ.

2.24 Нийгмийн хөгжлийн бодлогын 36 зорилтоос бүрэн хэрэгжсэн 14, дутуу хэрэгжилттэй 18, хэрэгжээгүй 4 асуудал буюу 65.0 хувийн биелэлттэй байна.

Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн зорилт 67.0 хувьтай хэрэгжсэн байна

2.25 Үндсэн чиглэлд төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн чиглэлээр төрийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилт бүхий 10 арга хэмжээг ХЗЯ, МХЕГ хариуцан хэрэгжүүлсэн байна.

2.26 Энэ салбарт тавигдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 67.0 хувьтай үнэлэгдэж бүрэн хэрэгжсэн 4, дутуу хэрэгжсэн 5, хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна.

2.27 Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх асуудалд Монгол Улсын иргэний үнэмлэхийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээнд ашиглаж ТҮЦ машинаар дамжуулан 23 төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэж эхэлсэн боловч уг машины ашиглалтын зардлыг ямар байгууллага хариуцах талаар дүрэм, журам боловсруулах арга хэмжээг зохион байгуулж чадаагүй байна.

2.28 Хууль зүйн салбарын бүх арга хэмжээ үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар үнэлэгдэхээр төлөвлөгдсөн нь дүгнэлт өгөхөд хүндрэлтэй болж, найдваргүй, тодорхойгүй шалгуур үзүүлэлт боловсруулснаас хэрэгжилтэд харьцуулалт хийх боломж хомс байна.

2.29 Хууль сахиулах байгууллагуудыг цахим мэдээллийн сүлжээнд холбох ажлын явц урьдчилсан судалгаа хийж, төслийг боловсруулах шатанд байна.

2.30 Гэмт хэргийн тухай, Мөрдөх албаны тухай зэрэг хууль зүйн салбарын суурь хуулиудын төслийг боловсруулж УИХ-ын холбогдох байнгын хороонд хүргэгдсэн боловч тайлант хугацаанд хэлэлцэгдээгүйгээс эрх зүйн шинэчлэлийн талаар тавьсан зорилт хэрэгжих шатандаа байна.

Гадаад бодлого, батлан хамгаалахын зорилт, арга хэмжээ 58.0 хувьтай хэрэгжсэн байна

2.31 Энэ бодлогын хүрээнд энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулах, батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлэх зорилт бүхий 9 арга хэмжээг ГХЯ, БХЯ хариуцаж бүрэн хэрэгжсэн 1, дутуу хэрэгжсэн 8 арга хэмжээ буюу хэрэгжилт 58.0 хувьтай байна.

2.32 Гадаад харилцааны бодлогын жил бүр дэвшигдэж байгаа дараах арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.

- 24.6-гийн манай улстай дипломат харилцаагүй, НҮБ-ын гишүүн улстай дипломат харилцаа тогтоох ажлыг идэвхтэй үргэлжлүүлэх арга хэмжээ 50 хувьтай,
- 24.7-гийн хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, хилийн чанадад монгол иргэдийн бүртгэлийн тогтолцоог сайжруулах арга хэмжээ 50 хувьтай,
- 24.3-ын Монголын бараа, бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээ 50 хувьтай,
- 24.4-ийн АНУ-тай стратегийн түншлэл, Канад Улстай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоох чиглэлээр ажиллах арга хэмжээ 50 хувьтай хэрэгжсэн байна.

2.33 Үндсэн чиглэлийн нийт арга хэмжээнээс зарим ТЕЗ-дын 10 арга хэмжээ хэрэгжээгүй нь дараах шалтгаантай байна. /Хавсралт В-д үзүүлэв/

- **Хөрөнгө, нөөц оновчтой зөв төлөвлөгдөөгүй шалтгаанаар:** ЗТЯ-ны нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах, БХБЯ-ны иргэдийг түрээсийн орон сууцаар хангах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх, АҮЯ-ны газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрийг барьж эхлэх зэрэг асуудлууд хэрэгжээгүй байна
- **Ажлын уялдаа холбоо, удирдлага, зохион байгуулалт сул, бүтээлч санаачлага дутагдсанаас шалтгаалж:** ЭМСЯ-ны Багийн спортыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, аймаг, нийслэл, сум, дүүрэгт явган аялах чиглэл тогтоож явган аялалыг хөгжүүлэх, хүн амыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ачааллыг багасгах, үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, гадаадын зарим орны экспортын болон бусад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ашиглах зэрэг арга хэмжээ байна.

2.34 Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан салбар бүрийн зорилт арга хэмжээний хэрэгжилт биелэлтийг хангах талаар зохиосон ажил бодитой үр дүнд төдийлөн хүрээгүй нь ТЕЗ-д хэрэгжилт, гүйцэтгэлийн үнэлгээг үр дүнд чиглүүлэн хянаж удирдахгүй, зохион байгуулалтаар хангах болон бодлогын дэмжлэг үзүүлэх талаар хангалтгүй, улсын төсөвт шаардлагатай хөрөнгийг төсөвлөж, санхүүжүүлж чадаагүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалсан байна.

Бүлэг 3. ТЕЗ-д үндсэн чиглэлийн биелэлт, гүйцэтгэлийн тайлагнал үр нөлөөтэй болоогүй байна

3.1 ЗГХЭГ-аас үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг яамдаас хагас бүтэн жилээр авч дүгнэж байгаа боловч бүрэн хэрэгжүүлэхэд яамдын ажлын зохион байгуулалтыг сайжруулан удирдах талаар санаачлага багатай ажиллажээ.

3.2 ТЕЗ-д 2014 оны үндсэн чиглэлийн биелэлтийг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын⁴ дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнд чиглүүлэн хийж тайлагнах ажил хангалтгүй, хэрэгжилтийн судалгааг хүргүүлсэн төдийгөөр асуудалд хандаж ЗГХЭГ-т иж бүрэн тайлан ирүүлж байх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй тохиолдол нийтлэг байна.

3.3 ЭМСЯ, УУЯ, ГХЯ, БХЯ, ЗТЯ, ХХААЯ зэрэг яамд тайландаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй, журмаа мөрдөөгүй үнэлгээ хийсэн иж бүрэн тайланг ЗГХЭГ болон Сангийн яаманд хүргүүлээгүй дутагдал давтагдсан байна.

3.4 Яамдын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ЭЗХЯ татан буугдаж улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт биелэлтийг нэгтгэн дүгнэх чиг үүрэг Сангийн яаманд шилжсэн бөгөөд арга хэмжээнээс “Гудамж төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх”, “Гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг татаж, бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх” зэрэг арга хэмжээний хэрэгжилт, биелэлтийг хариуцан тайлагнах байгууллага тодорхойгүй байв.

3.5 Сангийн яам улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх “Үндсэн чиглэл”-ийн биелэлтийг 73.3 хувь, ЗГХЭГ “63.7” хувь гэж үнэлжээ:

Хүснэгт №3.1 Хэрэгжилтийн үнэлгээ /хувиар

Бодлогын хамрах хүрээ	Үндсэн чиглэл /тоо/		Үнэлгээ /хувь/		
	зорилт	арга хэмжээ	Сангийн яам	ЗГХЭГ	ҮАГ
I. Макро эдийн засгийн бодлого	1	11	63.0	55.4	52.0
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	8	28	68.0	59.2	68.0
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	3	10	84.0	67.0	69.0
IV. Нийгмийн хөгжлийн бодлого	9	36	74.0	68.8	65.0
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэл	2	10	64.0	61.0	67.0
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	2	9	69.0	66.6	58.0

⁴ МУЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолын 4-р бүлгийн 18-дах заалт мөрдөнө. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэх бөгөөд яам нь тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Дүн	25	104	73.7	63.7	63.2
-----	----	-----	------	------	------

3.6 Аудитаар үндсэн чиглэлийн 104 арга хэмжээнээс 90-100 хувьтай буюу бүрэн биелсэн 32, 30-70 хувийн биелэлттэй 62, 10 арга хэмжээ хэрэгжээгүй, нийт зорилт, арга хэмжээний биелэлт 63.2 хувиар үнэлэгдлээ. /Дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт А, Б, В-д үзүүлэв/

3.7 Үндсэн чиглэлд тусгагдсан макро түвшний эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл:

Зорилт, арга хэмжээний		Шалгуур үзүүлэлт	Хүснэгт №3.2 Зорилт, арга хэмжээний	
			хүрэх түвшин	биелэлт
Д.д	Агуулга			
1.1	Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх;	ДНБ-ий бодит өсөлт	14.7	6.9
		1 хүнд ногдох ДНБ	5,300.0 ам.долл	4097.0
1.2	Эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг бууруулах;	Жилийн эцсийн инфляцийн зорилтот түвшин, хувиар	6	11
1.3	Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ төсвийн зохистой харьцааг хадгалах;	ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх %	35	28.7
		ДНБ-д төсвийн зарлагын эзлэх %	37	32.5
		ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	2.0	3.7

3.8 Үндсэн чиглэлийн биелэлтийн байдлын сүүлийн жилүүдийн судалгаагаар макро эдийн засгийн бодлогын зорилтот түвшний зарим үзүүлэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

3.9 Нэгдсэн төсвийн 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 6,223.4 тэрбум

төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 7,031.4 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 808.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ⁵.

3.10 ДНБ-ий өсөлт 2014 онд 6.9 хувьтай гарсан нь өмнөх оноос буурсан бөгөөд хүрэх түвшнээс 7.8 хувиар бага гарчээ.

- Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4097.0 ам.доллар байгаа нь өмнөх оноос бага зэрэг өссөн боловч зорилтот түвшинд хүрч чадаагүй байна.
- 2014 оны жилийн инфляци зорилтот түвшнээс 5 пунктээр илүү байна.
- ДНБ-д нэгдсэн төсвийн алдагдлын эзлэх хувь 2014 онд 3.7 хувьд хүрч зорилтот түвшинг хангаагүй байна.

3.11 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний 2014 оны хэрэгжилтийг өмнөх 3 жилтэй харьцуулбал,
Хүснэгт № 3.3

Үзүүлэлт	2011 он		2012 он		2013 он		2014 он	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хэрэгжсэн	152	32.1	17	29.4	55	11.7	32	30.7
Хэрэгжилт дутуу	305	64.5	120	63.2	101	82.8	62	60.3
Хэрэгжээгүй	16	3.4	8	7.4	10	5.5	10	9.0

⁵ Эх сурвалж: ҮСХ-ны 2014 оны 12 дугаар сарын статистикийн бюллетень 9 дүгээр тал

3.12 Хүснэгтээс үзэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний тоо буурсан боловч хэрэгжилтийн байдалд ахиц дэвшил гараагүй, хэрэгжилт дутуу арга хэмжээний тоо буураагүй зэрэг нь төсвийн зохистой бодлого үгүйлэгдсэн хэвээр байгааг илтгэж байна.

3.13 Сангийн яамны үнэлгээг ҮАГ-аас арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, тайлагналтай харьцуулан авч үзвэл:

Хүснэгт №3.4

/дундаж хувь, тоо/

Хариуцагч	Үнэлгээ		Аудитлагдсан				
	Яамдын үнэлгээ	Сангийн яам	Үнэлгээ	Арга хэмжээний тоо	Үүнээс		
					хэрэгжсэн	дутуу	хэрэгжээгүй
АҮЯ	77.5	73.3	52.0	6	-	5	1
БОНХАЖЯ	83.0	81.1	60.5	8	1	7	-
БСШУЯ	88.6	79.4	73.0	17	10	6	1
БХБЯ	86.3	67.5	57.5	7	2	3	2
БХЯ	70.0	70.0	63.0	2	-	2	-
ГХЯ	77.5	75.0	48.7	8	1	6	1
ЗТЯ	90.7	78.3	55.8	5	1	3	1
НЗДТГ	90.0	69.3	65.0	2	1	1	-
СЗХ	80.0	80.0	70.0	1	-	1	-
СЯ	75.0	64.6	68.0	5	1	4	-
УУЯ	68.3	61.7	60.0	10	3	6	1
ХАХНХЯ	68.0	66.0	50.0	4	-	4	-
ХЗЯ	83.3	68.7	70.9	7	3	4	-
ХХААЯ	81.6	71.7	56.0	4	2	2	-
ХЯ	85.0	85.0	65.0	2	1	1	-
ШСАА	100.0	90.0	90.0	1	1	-	-
ЭМСЯ	82.0	67.7	48.5	13	3	7	3
ЭХЯ	81.7	78.2	90.0	2	2	-	-
Дүн	73.3	73.7	63.2	104	32	62	10

3.14 Үндсэн чиглэлийн биелэлтэд ҮАГ-аас хийсэн үнэлгээний дундаж 63.2 хувь болж Сангийн яам, ЗГХЭГ-ын үнэлгээнээс 10.5 пунктээр буурч байна.

3.15 Үндсэн чиглэлд ТЕЗ-дын дангаар хэрэгжүүлэх 89 арга хэмжээ, толгойлон хэрэгжүүлэх 15 нийт 104 арга хэмжээ батлагдсан бөгөөд хэрэгжсэн 32 буюу 30.7 хувь, хэрэгжилт дутуу 62 буюу 60.3 хувь, хэрэгжээгүй 10 буюу 9.0 хувийг тус тус эзэлж байна.

3.16 Зорилтот түвшинд хүрээгүй болон биелэлт нь хангагдаагүй зорилт, арга хэмжээний шалтгаан, нөхцөл, үр дагаврын хамрах хүрээг тооцож үнэлээгүй, хэрэгжүүлэлтийн явцад гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх талаар ТЕЗ-даас зохиосон ажил хангалтгүй, энэ талаар асуудал дэвшүүлсэн, баримт, нотолгоо гэх зүйл алга байна.

3.17 Үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын хамрах хүрээгээр зорилтуудын хэрэгжилтийн байдлыг хүснэгт №3.5-д үзүүллээ.

Хүснэгт №3.5

Бодлогын хамрах хүрээ	Хэрэгжилтийн байдал, Үүнээс		
	хэрэгжсэн	хэрэгжилт дутуу	хэрэг-жээгүй
I. Макро эдийн засгийн бодлого	1	8	2
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	11	14	3
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	1	9	-
IV. Нийгмийн хөгжлийн бодлого:	14	18	4
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн бодлого:	4	5	1
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	1	8	-
Дүн	32	62	10

3.18 Эдийн засагт өсөлт саарснаас шалтгаалж зорилтуудын биелэлт хангалтгүй байна.

3.19 Үндсэн чиглэлд тусгагдсан нийгмийн хөгжлийн бодлогын хэрэгжээгүй асуудлын 3 нь спортын салбарыг хөгжүүлэх арга хэмжээ байна. Энэ нь ССАЖЯ-ны /хуучнаар/ хариуцсан арга хэмжээ байгаа бөгөөд тайлагнал байхгүйгээс хангалтгүй хэрэгжсэнд тооцогдсон байна.

3.20 Эдийн засагт хамгийн их нөлөө үзүүлэх бодит салбарын асуудлыг хариуцдаг УУЯ, ЭХЯ, БХБЯ, ХХААЯ зэрэг яамдын хариуцсан арга хэмжээний хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээгээр томоохон зорилт, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй гарч байна.

3.21 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлтөд давтамжийн хувьд жил бүр дахин дэвшигдсэн эдийн засгийн ач холбогдол бүхий арга хэмжээ батлагддаг ч хүрэх түвшин, үр дүнг сайтар тооцоогүй, нэгдсэн зохион байгуулалт, шуурхай удирдлага, бодлогын дэмжлэг дутмаг байдгаас хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. Жишээлбэл:

№	Зорилтын дугаар	Зорилтын агуулга, арга хэмжээ	2011	2012	2013	2014
1	3.2, 3.8	Зэс боловсруулах үйлдвэрийг барьж эхлэх	✓	✓		
2	7.2, 8.2, 2.2	Улаанбаатарт холимог тээврийн ачааны терминал, логистик төв байгуулах		✓	✓	✓
3	3.3, 8.1	Сайншандын аж үйлдвэрийн цогцолборыг барьж эхлэх	✓			✓
4	14.2	Их сургуулийн хотхоныг байгуулах, ажлыг эхлүүлэх, эрчимжүүлэх		✓		✓

Хэрэгжилт, тайлагнал үнэлгээний тогтолцоог шинэ түвшинд гаргах шаардлагатай

3.22 Ихэнх яамд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын шинж чанартай арга хэмжээнд тусгагдсан хөрөнгийг төсөвт тусгагдаагүй шалтгаан, төсөвлөгдсөн

хөрөнгөөс төсөвт батлагдсан тухайн арга хэмжээнд зарцуулсан тооцоо, санхүүжилтийн гүйцэтгэлийн талаар тайлагнадаггүй, энэ талаар баримт судалгаа алга байна.

3.23 Зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нэг бүрчлэн оновчтой тогтоодоггүй, хэрхэн хэмжигдэх нь тодорхойгүй байх, дахин дэвшигдсэн арга хэмжээний суурь болон өөрчлөлтийг хэмжих үзүүлэлтийг тодорхой болгох асуудал хэрэгжихгүй байна.

3.24 Яамдын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхид чанарын ахиц гарахгүй байгаа нь хэрэгжилтийг тайлагнасан байдлаас ажиглагдаж байгаа бөгөөд үр дүнд чиглүүлэн үнэлгээ хийдэггүй, харгалзах болон дэд шалгуур үзүүлэлтээр баталгаажуулж дүгнэхгүй байна.

3.25 ТЕЗ-д суурь үзүүлэлтэд тулгуурлан ахиц дэвшлийг тооцдоггүй, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэггүй, найдваргүй, холбиромтгой хэмжүүрээр үр дүн, хүрэх түвшинг үнэлэх дутагдал давтагдаж байгааг анхаарах цаг болсон байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилттэй холбогдуулан гарсан шийдвэрийн биелэлт хангалтгүй байна

3.26 Үндсэн чиглэлийн хэрэгжилт, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн төлөв байдалд сүүлийн 5 жилээр судалгаа хийж үзэхэд холбогдох байгууллага албан тушаалтанд нийтдээ 36 зөвлөмж өгөгдсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. /Хавсралт Г-д үзүүлэв/

3.27 ҮАГ-аас 2014 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдалд аудит хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ТЕЗ-д хангалттай ажиллаагүй бөгөөд төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлж ирсэн байна.

3.28 Үндсэн чиглэл болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, түүний тайлагналыг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор⁶ "... бодлогын зорилтууд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын шийдвэр нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг нягтлан тогтоох" гэж заасны дагуу яамд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн баримт бичгээр дамжин хэрэгжиж байгаа төрийн бодлого иргэдийн амьдралд ямар нөлөө үзүүлснийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт болон хэрэглэгчээр үнэлүүлсэн баримт байхгүй байна.

⁶ "Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ын 2-т заасан.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг зайлшгүй хэрэгцээ шаардлагад тулгуурлан үндэслэлтэй боловсруулах зохистой нэгдсэн арга зүй, стандартыг тогтоогоогүйгээс төлөвлөлт оновчтой болж чадаагүй байна.
- Үндсэн чиглэлд тусгах зорилт, арга хэмжээг анхан шатанд боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг, нэгдсэн удирдамжаар хангадаггүй, төлөвлөлтөд үнэлгээ дүгнэлт өгөхгүй байгаа нь хэрэгжих үндэслэлийг бууруулж байна.
- Үндсэн чиглэлийн арга хэмжээнд хөрөнгө, санхүүгийн нөөц төлөвлөгдөөгүй, эх үүсвэргүйгээс хэрэгжээгүй буюу хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ нэлээд байна.
- Хүрэх үр дүн, хэрэгжилтийг үнэлэх шалгуур тодорхой бус томъёологдсон арга хэмжээ үндсэн чиглэлд нэлээд орсон нь тэдгээрийн гүйцэтгэлийг тооцох, үнэлж дүгнэхэд бэрхшээлтэй байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Үндсэн чиглэл боловсруулах нэгдсэн арга зүй стандарттай болох талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах,
- Үндсэн чиглэлийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх бүх шатанд мэргэжил, арга зүйн нэгдсэн зөвлөгөө дэмжлэгээр хангаж ажиллах,
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг Засгийн газраас баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих журам тогтоож мөрдүүлэх.

Сангийн яамнаас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР А.ЗАНГАД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2015.04.02 № 5-2/1797
танай 2015.03.23 -ны № 590 -Т

Санал өгөх тухай

Танай байгууллагаас "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- 1.Тайлангийн төслийн Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдалд "Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан нийт 104 арга хэмжээнээс ҮХЦБ-д томъёологдсон 15, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 79 арга хэмжээг тусгасан нь" гэдгийг "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 104 арга хэмжээнд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогоос 15 арга хэмжээ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 80 арга хэмжээ тусгагдсан байна." гэж найруулгыг өөрчлөх,
- 2.Төслийн "Бүлэг 1"-ийн 1.8-д "Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт ороогүй" гэж үнэлж, дүгнэсэн нь Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт " Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд хөгжлийн бодлого, зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, тухайн жилд хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн томоохон арга хэмжээ, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдаа, хөрөнгийн эх үүсвэр, хариуцан хэрэгжүүлэх яам, байгууллагыг тусгана" гэж заасны дагуу жил бүрийн Үндсэн чиглэлийн төслийг боловсруулж байгаа тул тухайн жил бүр өөрчлөлт орох шаардлагагүй байгааг анхаарах,
- 3.Төслийн 3.17 дахь заалтад тусгагдсан Соёл, спортын аялал жуулчлалын яам /хуучнаар/-ны 3 арга хэмжээний /11.1; 11.2; 11.3/ биелэлтийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас тайлагнан ирүүлсэн тул түүнийг дахин авч үзэх,
- 4.Төслийн 3.11 дэх заалтад тусгагдсан яамдын үнэлгээг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалд үндэслэн эцэслэж, хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: 1 хуудас.

Хүндэтгэсэн,

САЙД



Ж.ЭРДЭНЭБАТ

ҮАГ-ын тайлбар
1-ийг үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
2-ыг үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
3-ыг үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
4-ийг үзнэ үү.

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Сангийн яамнаас ирүүлсэн саналд өгсөн тайлбар

ҮАГ-ын тайлбар 1

Тайлангийн төслийн Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал хэсэгт найруулгын өөрчлөлт хийх Сангийн яамны саналыг хүлээн авч “ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 104 арга хэмжээнд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан ҮХЦБ-оос 15, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс 80 арга хэмжээ тусгагдсан байна” гэсэн найруулгын өөрчлөлт хийв.

ҮАГ-ын тайлбар 2

Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дах хэсэгт заасны дагуу жил бүр Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа гэх боловч нэлээд арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин ерөнхий байдлаар төлөвлөгдсөн байгаа тул өөрчлөлт оруулах боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 3

Төслийн 3.17 дах заалтын хэрэгжилтийг ЭМСЯ-наас тайлагнаснаар авсан тул дахин авч үзэх боломжгүй байна.

ҮАГ-ын тайлбар 4

Төслийн 3.12 дах тусгагдсан яамдын үнэлгээг эцэслэн үнэлж ирүүлснийг хүлээн авч холбогдох засварыг хийхэд 73.7 хувьтай болж байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2015 оны 4 сарын 6 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн, 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яамд тус тус хүргүүлсүгэй.

Гурав. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Ерөнхий аудиторын зөвлөлд танилцуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын дарга /С.Төмөрхүү/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД

Хавсралт А

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зорилтын дугаар	Зорилт, арга хэмжээний агуулга	Хариуцан хэрэгжүүлэгч
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
1	1.3	Гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг татаж, бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх	ЗТ, БХБЯ, Монгол банк
ХОЕР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
2	3.1	Олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлэх	ЗТЯ
3	4.2	“Гудамж” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	ЭЗХЯ, ЗТЯ
4	4.4	ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр зам, авто зам, нефть, байгалийн хий, эрчим хүчний дэд бүтцийн урсгалыг бий болгох бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах	ЭЗХЯ, ЗТЯ, ЭХЯ
5	5.2	Эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих	УУЯ
6	5.3	Газрын тосны тухай, Ашигт малтмалын тухай хуулиудыг шинэчлэн боловсруулах,	УУЯ
7	6.1	Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх	ЭХЯ
8	6.2	Гэр хорооллын цахилгаан хангамжийг найдвартай болгох	ЭХЯ
9	7.1	Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	БХБЯ, ЭЗХЯ, ҮХААЯ, ХЯ
10	7.2	Барилгын төлөвлөлтийн норм, дүрэм, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөн боловсруулах	БХБЯ, ХЗЯ
11	8.2	Арьс шир, ноос, ноолуур, оёмол, сүлжмэл, мах сүүний чиглэлийн боловсруулах аж үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжин хөгжүүлэх	ҮХААЯ
12	8.5	Үр тариа болон жимс, жимсгэний ургацыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх	ҮХААЯ
ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
13	10.4	Европын холбооны болон олон улсын (ISO) шинэ дэвшилтэт стандарт, норм нормативыг нэвтрүүлэх	БОНХЯ
ДӨРӨВ.НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
14	13.3	Цалин хөлсний бодлогыг шинэчлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	ХЯ
15	16.1	Боловсролын байгууллагын олон улсын солилцооны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	БСШУЯ
16	16.2	Олон улсын жишигт нийцсэн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, арга зүй, технологийн шинэчлэл хийх	БСШУЯ
17	16.4	Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй технологийг багшид эзэмшүүлэх "Багшийн хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БСШУЯ
18	16.5	Инженерийн боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлж, олон улсын загварыг турших	БСШУЯ
19	16.7	“Өрсөлдөх чадвартай Монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлэх, дэлхийн шилдэг сургуулиудад оюутан сургах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх	БСШУЯ
20	17.4	Насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлж, олон нийтийн хандлага, төлөвшлийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	БСШУЯ

21	17.6	Их сургуулиудын хотхон байгуулах чиглэлээр ажиллах	БСШУЯ
22	17.7	Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг хөгжүүлэх	БСШУЯ
23	19.6	Уламжлалт эмийн түүхий эдийн стандартыг боловсронгуй болгох	ЭМСЯ
24	19.7	Эмийн чанарыг баталгаажуулах стандартыг боловсруулах	ЭМСЯ
25	19.10	“Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	ЭМСЯ
26	20.1	Хөдөө орон нутгийн соёлын төвүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих	БСШУЯ, ССАЖЯ
27	20.2	Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	БСШУЯ, ССАЖЯ
ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ			
28	22.1	Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх	ХЗЯ
29	22.2	Эрүүгийн бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх	ХЗЯ
30	22.5	Хилийн шалган нэвтрүүлэх тогтолцоог шинэчлэх	ХЗЯ
31	22.8	Хилийн боомт дахь хяналт шалгалтыг эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүнд чиглүүлж, аюулгүйн үзүүлэлтэд суурилсан хяналт, шинжилгээг өргөжүүлэх	ХЗЯ, МХЕГ
ЗУРГАА.ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ			
32	24.2	Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах	ЭЗХЯ

Хавсралт Б

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ ДУТУУ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зорилтын дугаар	Зорилт, арга хэмжээний агуулга	Хариуцан хэрэгжүүлэгч
НЭГ.МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
1	1.1	Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх	ЭЗХЯ
2	1.2	Эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг бууруулах Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ЭЗХЯ, УУЯ
		Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ҮХААЯ, ЗТЯ, БХБЯ
3	1.4	Баялгийн сангийн тогтолцоог Монгол Улсад бий болгон хөгжүүлэх	СЯ
4	1.5	Нийгмийн даатгалын санг мөнгөжүүлэх замаар ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг эхлэх	ЭЗХЯ, БХБЯ, ХАХНХЯ,
5	1.7	Гадаад худалдааны гол түнш улсуудтай тухайн улсын валютаар арилжаа хийх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллах	ЭЗХЯ
6	1.8	Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, төсвийн зохистой харьцааг хадгалах	СЯ
7	1.9	Үнэ, тарифын тухай хуулийг шинээр боловсруулж, хэрэгжүүлэх	ЭЗХЯ
8	1.10	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	СЗХ
ХОЕР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
9	2.1	Төмөр замын суурь бүтцийг барих бодлогыг хэрэгжүүлэх	ЗТЯ
10	2.2	Холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах бодлого хэрэгжүүлэх	ЗТЯ
11	4.1	Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх	ЗТЯ
12	5.1	Геологийн албыг бэхжүүлж, геологийн судалгааг өргөжүүлэх	УУЯ
13	5.4	Стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийж, нөөцийг тогтоосон зарим ордыг стратегийн ач холбогдол бүхий ордод хамруулах	УУЯ
14	5.5	Шатдаг занарын эрэл хайгуулыг идэвхжүүлж, шатдаг занараас шатахуун гаргах үйлдвэр, туршилтын ажлыг эхлүүлэх	УУЯ
15	5.6	Эзэнгүй, эвдрэлтэй талбайг нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх	УУЯ
16	5.8	Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын шатахууны нөөц хадгалах агуулахыг байгуулах	УУЯ
17	5.9	Хийн түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлж, холбогдох норм, стандартыг шинэчлэн боловсруулах	УУЯ
18	8.1	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх	АҮЯ, ҮХААЯ, ЭЗХЯ

19	8.3	Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	ҮХААЯ
20	8.4	Био бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	ҮХААЯ
21	9.1	Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх "Аялал жуулчлал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БОНХАЖЯ, ССАЖЯ
22	9.2	Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх	БОНХАЖЯ, ССАЖЯ
ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
23	10.1	Иргэн, аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг дэмжиж, ногоон эдийн засгийн хөгжлийн орчныг бүрдүүлэх чиглэлээр татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	БОНХАЖЯ
24	10.2	Үндэсний байгаль, соёл, түүхийн өв газруудын хил хязгаарыг тогтоох	БОНХАЖЯ
25	10.3	Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах	НЗДТГ
26	10.5	"Саарал" усыг эргүүлэн ашиглахтай холбогдсон норм, стандартыг батлуулах	БХБЯ, БОНХЯ
27	11.1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх	БОНХАЖЯ
28	11.2	Уур амьсгалын өөрчлөлтөд өртөх нэн ховор, ховордсон амьтдын эрсдэлийн үнэлгээ хийх, сэргээн нутагшуулах, үржүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БОНХАЖЯ
29	11.3	Устах аюулд орж байгаа ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, нэн ховор, ховор ургамлыг тарималжуулах, генофондыг бий болгох	БОНХАЖЯ
30	12.1	Аймгийн төвүүдийг хөгжүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	БХБЯ, ЭЗХЯ, СЯ, ЭХЯ
31	12.2	"Сум" төслийг хэрэгжүүлж эхлэх	АҮЯ, ЭЗХЯ
ДӨРӨВ.НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
32	13.1	Түр ажилтныг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг, урамшуулал олгох	ХЯ
33	13.2	Хот, суурингаас хөдөө орон нутагт шилжин суурьших, ажил эрхлэх санаачилгыг зээл, санхүүгийн дэмжлэг, урамшууллын бодлогоор дэмжих	АҮЯ,ХЯ, ЭЗХЯ
34	14.1	Эх /эцэг/ нь төрүүлсэн хүүхдээ хоёр нас хүртэл, ихэр хүүхдийг гурван нас хүртэл өөрөө асран хүмүүжүүлэх тэтгэмж, дэмжлэгийн эрх зүйн орчныг бий болгох	ХАХНХЯ, СЯ
35	15.1	Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчлэх	ХАХНХЯ
36	15.2	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдад зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан, хөтөлбөрийг бий болгох	ХАХНХЯ
37	16.6	Багш, инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	БСШУЯ
38	17.1	Хүүхэд бүрийг авьяаст нь тулгуурлан хөгжүүлэх "Авьяас" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БСШУЯ
39	17.2	Хүүхэд бүрд ном уншуулах эрмэлзэл төрүүлэх, унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх "Ном" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БСШУЯ
40	17.3	Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг тогтолцооны хэв шинжид оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, үнэлгээг сайжруулж, багшлах боловсон хүчнийг	БСШУЯ

		бэлтгэн мэргэшүүлж, давтан сургаж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгох	
41	17.5	Техник, технологийн чиглэлээр Монгол-Германы хамтарсан дээд сургууль байгуулах ажлыг эхлүүлэх	БСШУЯ
42	18.1	Монгол судлалын сан байгуулж үйл ажиллагааг нь төрөөс тусгайлан дэмжих	БСШУЯ
43	19.1	Эрүүл мэндийн салбарын ажилтны хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх	ЭМСЯ
44	19.2	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг өргөжүүлэх	ЭМСЯ, ХАХНХЯ
45	19.3	Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх	ЭМСЯ
46	19.4	Эмнэлгийн яаралтай тусламжийн хүрээг өргөтгөх	ЭМСЯ
47	19.5	Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	ЭМСЯ
48	19.8	Эмийн аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлж, импортын болон дотоодын үйлдвэрлэгчдийн эмийн худалдаанд хяналт тавих	ЭМСЯ
49	19.9	Эм ханган нийлүүлэх тогтолцоог бэхжүүлэх	ЭМСЯ
ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ			
50	22.3	Хорих байгууллагын тогтолцоог шинэчлэх	ХЗЯ
51	22.4	“Улсын хил хамгаалалтын техник хангамжийг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	ХЗЯ
52	22.6	Хуулийн боловсролын шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ХЗЯ
53	22.7	Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх	ХЗЯ
54	23.2	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх	БХБЯ, БСШУЯ, СЯ, ОБЕГ
ЗУРГАА.ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ			
55	24.1	Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	АҮЯ, ЭЗХЯ
56	24.3	Монголын бараа, бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх	ГХЯ, Холбогдох яам
57	24.4	АНУ-тай стратегийн түншлэл, Канад Улстай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоох чиглэлээр ажиллах	ГХЯ
58	24.5	Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийг үүсгэн байгуулах олон улсын хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгож, үйл ажиллагааг эхлүүлэх	ГХЯ
59	24.6	Манай улстай дипломат харилцаагүй, НҮБ-ын гишүүн улстай дипломат харилцаа тогтоох ажлыг идэвхтэй үргэлжлүүлэх	ГХЯ
60	24.7	Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, хилийн чанад дахь монгол иргэдийн бүртгэлийн тогтолцоог сайжруулах	ГХЯ
61	25.1	Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр төслүүдийг хэрэгжүүлэх	БХЯ

62	25.2	"Мэргэжлийн анги, байгууллагыг бүсчлэн байгуулах" төслийн хүрээнд улсын хэмжээний бүтээн байгуулалтын ажилд оролцох ангиудыг бүсчлэн байгуулж эхлэх;	БХЯ
----	------	--	-----

Хавсралт В

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН “0-10” ХУВИЙН БИЕЛЭЛТТЭЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зорилтын дугаар	Зорилт, арга хэмжээний агуулга	Хариуцан хэрэгжүүлэгч
НЭГ.МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
1	1.6	Гадаадын зарим орны экспортын болон бусад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ашиглах	УУЯ, ЭЗХЯ, ГХЯ,
2	1.11	Банк, санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах чиглэлээр ажиллах	ЭЗХЯ
ХОЁР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
3	4.3	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах	ЗТЯ
4	5.7	Газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрийг барьж эхлэх	УУЯ
5	7.3	Иргэдийг түрээсийн орон сууцаар хангах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	БХБЯ, СЯ, НЗДТГ
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
6	16.3	Цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ажлын ачааллыг багасгах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	БСШУЯ
7	21.1	Багийн спортыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;	ЭМСЯ
8	21.2	Аймаг, нийслэл, сум, дүүрэгт явган аялах чиглэл тогтоож, явган аяллыг хөгжүүлэх;	ЭМСЯ
9	21.3	Хүн амыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх	ЭМСЯ
ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ			
10	23.1	Эрдэнэт, Дархан, Хархорин, Ховд, Улиастай, Зуунмод болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх	БХБЯ, АНЗДТ, ТББ

- 34 -

[illegible]



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Аудитыг гүйцэтгэсэн:

УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор:
С.Төмөрхүү

Чиглэлийн аудитын албаны менежер: Л.Эрдэнэчулуун

Ахлах аудитор Ж.Эрдэнэ
Р.Гончигцэрэн

Чиглэлийн аудитын албаны аудитор, шинжээчид
Л.Авирмэд
Ж.Оюунтуяа
Ш.Наранбаатар
Б.Буянхишиг

УАГ-ын харьяа аймаг, нийслэлийн аудитын газрын болон ГАГ-ын Төсвийн гүйцэтгэл, Хөрөнгө оруулалтын албаны аудитор, шинжээч нар

Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 263755, 262451, 261805 дугаарын утсаар харилцана уу.
Аудитын тайланг
УАГ-ын "www.audit.mn" сайтаас үзнэ үү.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160
МОНГОЛ УЛС

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3

Аудитын хураангуй

▪ Оршил	5
▪ Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал	5
▪ Сайжруулах асуудал	5

Бүлэг 1. Үндсэн чиглэлийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад ахиц өөрчлөлт гараагүй байна

▪ Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт гараагүй байна	6
▪ Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр нь зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй байна	7
▪ Зорилт, арга хэмжээг судалгаа тооцоонд үндэслэн бодитой төлөвлөхгүй байна	8
▪ Зорилт, арга хэмжээний төлөвлөлтөд ХШҮ хийж байх шаардлагатай	8

Бүлэг 2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил бодитой үр дүнд хүрээгүй байна

▪ Зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ дутагдаж үндсэн чиглэлийн биелэлт 63.2 хувьтай байна	10
▪ Макро эдийн засгийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн хүрэх түвшний үзүүлэлт хангагдаагүй байна	10
▪ Бодит салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө бага төлөвлөгдөж хэрэгжилт 68.0 хувьтай байна	11
▪ Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн зорилтоос ногоон хөгжлийн асуудал хангалттай хэрэгжээгүй байна	12

Агуулга

- Үргэлжлэл -

■ Нийгмийн хөгжлийн бодлогын зорилт, арга хэмжээ 57.8 хувьтай хэрэгжсэн байна	14
■ Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн зорилт 67.0 хувьтай хэрэгжсэн байна	14
■ Гадаад бодлого, батлан хамгаалах зорилт, арга хэмжээ 58.0 хувьтай хэрэгжсэн байна	
Бүлэг 3. ТЕЗ-д үндсэн чиглэлийн биелэлт, үр дүнг бодитой үнэлэлгүй гүйцэтгэлийг тайлагнасан байна	17
■ Эдийн засгийн өсөлтөөс шалтгаалж, макро түвшний үзүүлэлтүүд бүрэн биелэгдээгүй байна	19
■ Хэрэгжилт, тайлагналыг үнэлж буй үнэлгээний тогтолцоог шинэ түвшинд гаргах шаардлагатай байна	20
■ Үндсэн чиглэлийн хэрэгжилттэй холбогдуулан гарсан шийдвэрийн биелэлт хангалтгүй байна	21
	22
Аудит дүгнэлт	
Аудитын зөвлөмж	
Холбогдох байгууллагын санал:	
Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал	
Хоёр. Сангийн яамнаас ирүүлсэн санал	
Саналд өгсөн тайлбар:	
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ	
ХАВСРАЛТУУД:	
Хавсралт А. “Үндсэн чиглэлийн хэрэгжсэн зорилт, арга хэмжээний жагсаалт”	23
Хавсралт Б. “Үндсэн чиглэлийн хэрэгжилт дутуу зорилт, арга хэмжээний жагсаалт”	25
Хавсралт В. “Үндсэн чиглэлийн “0-10” хувийн биелэлттэй зорилт, арга хэмжээний жагсаалт”	28
Хавсралт Г. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөв байдлын судалгаа	29

Товчилсон үгийн жагсаалт

АНАГ	Аймаг, нийслэлийн аудитын газар
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГУАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗТЯ	Зам, тээврийн яам
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗЯ	Хууль зүйн яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
УУЯ	Уул уурхайн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ҮХЦБ	“Үндэсний хөгжлийн цогц бодлого”
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМСЯ	Эрүүл мэнд, спортын яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг Улсын Их Хурлын 2011 оны 34 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2015 онд нийлүүлэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдлыг шалган дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Үндсэн чиглэлийн арга хэмжээ оновчтой төлөвлөгдсөн эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд зорилт, арга хэмжээний биелэлтийг хангахуйц үр нөлөөтэй ажлыг зохион байгуулсан эсэх,
- Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд биелэлт, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж, үр дүнг тооцсон эсэх.

Хамарсан хүрээ

Улсын Их Хурлын 2013 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх болон биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах үүрэг хүлээсэн Төрийн захиргааны төв байгууллага, тэдгээрийн ажлын албадыг хамруулан гүйцэтгэв.

Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг тэдгээрийн гаргасан тайлагналд үндэслэн ҮАГ-ын харьяа аймаг, нийслэл дэх аудитын газрууд үзэж танилцан тодруулга, судалгаа ирүүлсэн болно.

Арга зүй стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас гаргасан биелэлтийн тайланд судалгаа хийж үнэлэх,
- Хөрөнгийн эх үүсвэрийн уялдааг судлах, гүйцэтгэлийг харьцуулах,
- Холбогдох төрийн байгууллагын албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судлах,
- Яамдын хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлсэн дотоод аудитын нэгжийн үнэлгээ, тайланг судлах, ҮАГ-аас 2011, 2012, 2013 онд хийсэн аудитын дүгнэлт, өгсөн зөвлөмж, санал асуулгын дүнг нягтлах, харьцуулалт хийх, нөхцөл байдлыг үнэлэх,
- ТЭЗ бүрээр аудитын урьдчилсан тайланг бэлтгэж, хэрэгжилтийн байдлыг танилцуулах,

- Санхүү төсвийн асуудал болон хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан төрийн байгууллагуудаас гаргасан улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, төрөөс баримтлах урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт материалд тулгуурлан судалгаа хийх,
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн нотлох зүйлстэй тулган шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах,
- Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг тэдгээрийн гаргасан тайлагналд үндэслэн ҮАГ-ын харьяа аймаг, нийслэл дэх аудитын газрууд батлагдсан хөтөлбөр, аудитын арга зүй, горимын дагуу нотлох зүйлс цуглуулан судалгаа гарган, тодруулга хийх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн орон нутагтай хамаарах асуудлыг АНАГ-ын аудитор, шинжээч нар тодруулж судалгааг ирүүлэв.

Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орж ЭЗХЯ татан буугдсантай холбоотойгоор ТЕЗ-дын хариуцах арга хэмжээг шинээр байгуулагдсан яамдад шилжүүлэх, тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэх ажил удааширсан байна.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль, 2004 оны 2 дугаар тогтоолын дагуу Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг жил бүрийн эхний улиралд УИХ-д танилцуулахаар журамласан нь аудитыг гүйцэтгэх, нэгдсэн дүгнэлт гаргахад төлөвлөгөөт хугацаанд багагүй нөлөөлж байгаа бөгөөд мөн оны төсвийн болон хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, улсын нэгдсэн статистик дүн мэдээ эцэслэн гараагүй нь цаг хугацааны хувьд бодитой үнэлгээ, дүгнэлт гаргахад сөргөөр нөлөөлж байна.

Аудитын хураангуй

Оршил

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулсан бөгөөд түүний үндэслэл, хүчин зүйлсийн нөлөөлөл, оршин буй нөхцөл байдлын талаарх дүнг холбогдох дарааллаар тайлангийн I, II, III бүлэгт харуулав.

Засгийн газраас улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хангуулах нэгдсэн төлөвлөгөө батлаагүй бөгөөд төрийн төв байгууллагууд үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдал

Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн нийт 104 арга хэмжээнээс ҮХЦБ-д томьёологдсон 15, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 79 арга хэмжээг тусгасан нь бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байна.

Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд буюу ТЕЗ-д биелэлтээ “73.3” хувь, Сангийн яам “71.0” хувиар, харин ЗГХЭГ “63.7” хувиар тус тус үнэлсэн байна.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, арга зүйн дагуу хийсэн дүн шинжилгээ, үнэлгээний дүнгээр нийт 104 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 32, хэрэгжилт дутуу 62, хэрэгжээгүй 10 буюу биелэлт “63.2 хувьтай байна.

Сайжруулах асуудал

ЗГХЭГ, ТЕЗ-даас үндсэн чиглэлийн биелэлтийг хангахад гарч буй зардлын үр ашиг, үр дүнг тооцох арга зүйг боловсруулан ашиглах, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил тодорхой үр дүнд хүрээгүй, зарчмын өөрчлөлт үгүйлэгдэж байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжих хугацаа, хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй уялдуулан төлөвлөөгүй, хэрэгжилт биелэлтэд ТЕЗ-дын шуурхай удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг, эрх зүйн шинэчлэлийн арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.

Эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах талаар ТЕЗ-даас зохион байгуулж, үр дүнд хүрсэн ажил хангалтгүй байгаа нь асуудлыг шийдвэрлэх талаар санаачлага дутагдаж байгааг харуулж байна.

Бүлэг 1. Үндсэн чиглэлийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад ахиц өөрчлөлт гараагүй байна

1.1 Үндсэн чиглэлийн төлөвлөлт, түүнийг боловсруулахад хууль тогтоомжийн шаардлагыг баримтлан хэрэгжих үндэслэл, үр дүнг урьдчилан тооцсон, хамрах хүрээг оновчтой төлөвлөсөн, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур, хүрэх түвшин, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн тооцоолол бодитой эсэхэд тулгуурлав.

1.2 Үндсэн чиглэлийн нийт 104 арга хэмжээний шалгуур үзүүлэлт хүрэх түвшинд хийсэн судалгаагаар үзэхэд 44 буюу 42.3 хувийг “үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар” үнэлэхээр, 55 арга хэмжээ буюу 52.8 хувь нь хөрөнгийн эх үүсвэргүй төлөвлөгдсөн нь биелэлтийг тооцоход тодорхойгүй шалгуур хэрэглэсэн, харьцуулалт хийхэд хүндрэлтэй, суурь үзүүлэлтийн тооцоо судалгаагүй төлөвлөгджээ.

1.3 Уул уурхай, Эрүүл мэнд, спорт, Хууль зүй зэрэг салбарын зорилт, арга хэмжээний дийлэнх нь үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар үнэлэгдэхээр төлөвлөгдсөн байна. Жишээлбэл: Эрчим хүчний салбарт “Гэр хорооллын цахилгаан хангамжийг найдвартай болгох” зорилтын 2014 онд хүрэх түвшинг тодорхойлохдоо Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийн 4 жилд хэрэгжүүлэх зорилтыг бүтнээр тавьсан байна.

1.4 УИХ-ын 39 дүгээр тогтоолоор баталсан улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 6 бодлогын хүрээний нийт 25 зорилт, 104 арга хэмжээ тусгагджээ¹.

1.5 Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээний тоо 2014 онд буурсан ч нийгмийн хөгжлийн бодлогын хүрээний асуудалд ач холбогдол өгсөн байна.

Бодлогын хамрах хүрээ	Хүснэгт №1.1 УИХ-ын 2013 оны 39 дүгээр тогтоол	
	Зорилт	Арга хэмжээ
I. Макро эдийн засгийн бодлого	1	11
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	8	28
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	3	10
IV. Нийгмийн хөгжлийн бодлого	9	36
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэл	2	10
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	2	9
Нийт	25	104

Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт ороогүй байна

1.6 УИХ-аас үндсэн чиглэлийг батлахдаа “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-той уялдуулан Засгийн газраас хэрэгжилтийг оны эхнээс хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг даалгасан байна².

1.7 Засгийн газраас “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн биелэлтийг ТЕЗ-даас хагас бүтэн жилээр гаргуулж ажилласан ч үр дүн, үр нөлөөт байдлын үнэлгээний ажил, хэрэгжүүлэх талаар зохиосон ажил хангалттай бус, саналыг авч, нэгтгэн дүгнэсэн, урьдчилсан тооцоо судалгаа хийлгэсэн баримт Сангийн яам болон ЗГХЭГ-т алга байна.

¹Улсын Их Хурлын 2004 оны 2 дугаар тогтоолоор баталсан журмын 1.2-т “... үндсэн чиглэл нь Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн стратеги, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах бодлогын баримт бичиг болохыг заасан.

²Эх сурвалж: Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр тогтоол

1.8 Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн бүтэц, агуулгад зарчмын өөрчлөлт ороогүй, төлөвлөлт, судалгаа, тооцооллын үндэслэлийг сайжруулах талаар өмнөх жилүүдтэй харьцуулахад дорвитой ахиц дэвшил ажиглагдахгүй байна.

1.9 Үндсэн чиглэлд туссан макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдэд хэрхэн төлөвлөж байсныг авч үзвэл:

Хүснэгт №1.2

Зорилт, арга хэмжээний төлөвлөлт	Хүрэх түвшин /оноор/			
	2011	2012	2013	2014
ДНБ-ий бодит өсөлт /%-уар/	8.2	16.6	19.0	14.7
Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ /ам.долл/	2076.5	3900.0	4930.0	5300.0
Инфляцийн түвшин /%-уар/	9.7	9.0	8.0	6.0
ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх хувь	35.4	29.8	39.2	32.1
ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн зарлагын эзлэх хувь	40.4	36.5	41.2	33.9
ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	5.0	6.7	2.0	2.0

1.10 МЭЗ-ийн төлөвлөсөн зарим үзүүлэлтийн хувьд 2014 онд ДНБ-ий бодит өсөлтийг 14.7 хувьд хүргэн, инфляцийн зорилтот түвшинг 6.0 хувьд байлгах, төсвийн алдагдлыг бууруулах зэргээр эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого, зарчмыг мөрдлөг болгохоор төлөвлөсөн байна.

Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр нь зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй байна

1.11 Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг ашиглахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №1.3

/тбм.төг/

№	Эх үүсвэрийн ангилал	Үндсэн чиглэл /оноор/			
		2011	2012	2013	2014
1	Улсын төсөв	357.8	1 964.5	2 108.6	362.5
2	Гадаад эх үүсвэр	81.7	198.3	367.8	516.6
3	Гадаадын хөрөнгө оруулалт	338.0	-	-	-
4	ТХХТ	2 091.8	440.5	697.0	-
5	Уул уурхайн орлого	513.0	-	-	-
6	Хувийн хөрөнгө оруулалт	-	952.2	615.7	4.0
7	Орон нутгийн төсөв	-	2.8	-	-
8	Хүний хөгжил сан	-	23.0	-	-
9	Гадаадын зээл, тусламж	183.7	-	-	-
10	Тусгай сан, бусад эх үүсвэр	247.2	-	116.7	-
	ДҮН	3 813.2	3 581.3	3 905.8	883.1

1.12 Үндсэн чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад 3,022.7 тэрбум төгрөгөөр, түүний дотор улсын төсвийн эх үүсвэр 1,746.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах хэмжээний санхүүгийн эх үүсвэр болоогүй байна.

1.13 Үндсэн чиглэлийн 104 арга хэмжээнээс 47.2 хувьд буюу 49 арга хэмжээнд нийтдээ 883.1 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс улсын төсвөөс 45, гадаад эх үүсвэрээс 3, хувийн хэвшлийн

хөрөнгөөр 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр болж, бодит салбарын бодлогод нийт 624.5 тэрбум төгрөг төлөвлөсөн нь эх үүсвэрийн 70 орчим хувийг эзэлж байна.

1.14 Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шинжтэй арга хэмжээний эх үүсвэрт 362.5 тэрбум төгрөг төлөвлөсөн нь нийт эх үүсвэрийн 41.0 хувийг эзэлж, хөрөнгө төсөв зайлшгүй шаардлагатай 10 арга хэмжээнд хөрөнгө төлөвлөгдөөгүй байна.

1.15 Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөд үндсэн чиглэлд тусгагдсан хөрөнгө оруулалтын шинжтэй 74.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 арга хэмжээнд 20.1 тэрбум төгрөг батлагдсан байна.

1.16 Хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг санхүү, хөрөнгийн эх үүсвэр батлагдаагүй төлөвлөлтийн алдаатай бодлоготой холбон тайлбарлаж байгаа боловч бусад нөөц, эх үүсвэрийг ашигласан талаар болон ямар нэг шийдэл, нөхцөл байдалтай уялдуулсан шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

Зорилт, арга хэмжээг иж бүрэн судалгаа тооцоонд үндэслэн бодитой төлөвлөхгүй байна

1.17 ТЕЗ-дын арга хэмжээний төлөвлөлтөд дүн шинжилгээ хийж үзвэл:

Хүснэгт №1.4

Бодлогын хамрах хүрээ	Арга хэмжээний тоо	Төлөвлөлтийн үндэслэл			
		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	Хөрөнгө, нөөцийг тооцоогүй	Шалгуур болон хүрэх түвшинг гаргаагүй	Бусад хөтөлбөр, салбарын бодлоготой уялдаагүй
I. Макро эдийн засгийн бодлого	11	11	1	-	2
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	28	10	7	1	1
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	10	1	1	-	-
IV. Нийгмийн хөгжлийн бодлого	36	13	2	1	4
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэл	10	5	-	1	1
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	9	4	-	-	-
Нийт	104	44	11	3	8

1.18 Бодит салбарын хөгжлийн бодлогын 28 арга хэмжээнээс 19 нь үйл ажиллагааны хэрэгжилтээр төлөвлөгдсөний дотор төсөв хөрөнгө шаардлагатай дараах арга хэмжээ байсан нь эдийн засагт өсөлт, үр ашгийг бий болгох салбарт хөрөнгө нөөц дутагдалтай төлөвлөгдсөнийг илтгэж байна. Жишээлбэл,

- 1.5-ын нийгмийн даатгалын санг мөнгөжүүлэх замаар ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх,
- 5.1-ийн геологийн албыг бэхжүүлж, геологийн судалгааг өргөжүүлэх,

- 5.2-ын эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих,
- 5.5-ын газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрийг барьж эхлэх,
- 5.6-ын эзэнгүй, эвдрэлтэй талбайг нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх
- 5.8-ын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын шатахууны нөөц хадгалах агуулахыг байгуулах гэх мэт хөрөнгө шаардсан ажлууд байна

1.19 ТЭЗ-даас зорилтот түвшин, харгалзах үзүүлэлт, үр дагаврын хамрах хүрээг ерөнхий байдлаар төлөвлөдөг дутагдал давтагдсаар байгаа нь төлөвлөлтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хүлээгдэж буй үр дүнг бодитой тооцох, байгууллагын ХШҮ-ний ажлын зохион байгуулалт хангалтгүйтэй холбоотой байна.

1.20 Үндсэн чиглэлд үйл ажиллагааны хэрэгжилт, явцаар төлөвлөгдөж буй он дамжин хэрэгжих зорилт, арга хэмжээний хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт тодорхойгүй нь эцсийн үр нөлөө, хэрэгжилт хангалтгүй, биелэлтийг бодитой үнэлэхэд бэрхшээлтэй байна

Бүлэг 2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажил бодитой үр дүнд хүрээгүй байна

Зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ дутагдалтайгаас 35.1 хувь нь хэрэгжээгүй байна

2.1 Яамд эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан асуудлыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан байна.

2.2 Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 160 дугаар тушаалаар баталсан өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөн гэсэн шалтгаанаар ТЕЗ-даас гаргаж ирүүлээгүй бөгөөд ЗГХЭГ-аас энэ талаар ямар нэг зохицуулалт хийж нэгтгэн зохион байгуулаагүй байна.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн хүрэх түвшний үзүүлэлт хангагдаагүй байна

2.3 Сангийн яамны тайлагнаснаар макро эдийн засгийн бодлогын асуудал 65 хувьтай хэрэгжсэн бол аудитаар энэ хүрээнд тусгагдсан 9 зорилтоос бүрэн хэрэгжсэн 1, дутуу хэрэгжсэн 7, хэрэгжээгүй 2 арга хэмжээ 52 хувийн биелэлттэй байгаа нь эдийн засгийн гол үзүүлэлт буурсан, гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг татаж бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх, нүүрс, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний экспортын өсөлтийг хадгалахаар төлөвлөсөн боловч олон улсын зах зээл дээр голлох түүхий эдийн үнэ унаж, эдийн засагт өсөлт төдийлөн гараагүйтэй холбоотой байна.

2.4 Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 70 орчим хувиар буурснаас эдийн засгийн өсөлтийн хурдац төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

2.5 ЭЗХЯ /хуучин нэрээр/ дангаар болон хамтран хэрэгжүүлэх макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангаж эдийн засгийг эрчимжүүлэх чиглэлийн дараах арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- 1.1-ийн эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ 50 хувьтай,
- 1.2-ын эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг бууруулах арга хэмжээ 50 хувьтай;
- 1.7-ийн гадаад худалдааны гол түнш улсуудтай тухайн улсын валютаар арилжаа хийх тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ 30 хувийн;
- 1.9-ийн үнэ, тарифын тухай хуулийг шинээр боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 50 хувийн;
- 1.11-ийн банк, санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Бодит салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө бага төлөвлөгдөж, гүйцэтгэл 68.0 хувьтай байна

2.6 Бодит салбарын хөгжлийн бодлогын гол асуудлыг АҮЯ, БХБЯ, ЗТЯ, ЭХЯ, УУЯ, ХХААЯ хариуцан хэрэгжилт, биелэлтийг үнэлж байгаа бөгөөд 28 арга хэмжээнээс 19-т нь тайлант онд хөрөнгийн ямар ч эх үүсвэр төлөвлөгдөөгүй нь гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

2.7 Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогыг эрчимжүүлэх, агаарын тээврийн салбарыг хөгжүүлэх, зам дэд бүтэц, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх, барилгын салбарт дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрлэл, ХАА-н салбарыг хөгжүүлэх, аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэргээр төлөвлөгдөж биелэлт 68.0 хувийн гүйцэтгэлтэй байна³.

2.8 Улс орны хөгжилд чухал үүрэгтэй Ухаа худаг-Гашуун сухайт, Чойбалсан- Бичигт, Ухаа худаг- Сайн шанд-Хөөт чиглэлд төмөр замын суурь дэд бүтцийг барих асуудалд улсын төсвөөс хөрөнгө тусгаагүй боловч Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны 88.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлж эхэлсэн боловч гүйцэтгэл 40 гаруй хувьтай үргэлжилж байна.

2.9 Аймгийн төвүүдийг нийслэлтэй холбосон хатуу хучилттай 775.4 км авто зам барихаар төлөвлөж 2014 онд 500 км зам ашиглалтад оруулсан нь төлөвлөсөн үзүүлэлтийн 64.5 хувь болж байна. Өмнөх жилтэй харьцуулахад барьж ашиглалтад оруулсан зам 33.8 км-ээр бага байна.

2.10 Эрдэс баялгийн салбарт дэвшүүлсэн 9 арга хэмжээнд улсын төсвөөс ямар ч хөрөнгө төлөвлөөгүй бөгөөд стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, шатдаг занараас шатахуун гаргах үйлдвэр байгуулах зэрэг чухал ач холбогдолтой төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байгаа нь төрийн байгууллагуудын улс орны эдийн засаг, нийгмийн өмнө хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт удаашралтай, хяналт сулаас гүйцэтгэлд муугаар нөлөөлсөн байна.

2.11 “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор барих ажил жил бүрийн үндсэн чиглэлд тусгагдаж байгаа ч ажлын явц хангалтгүй, дорвитой ахиц гараагүй, холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах бодлого хэрэгжүүлэх ажлын явц, хэрэгжилт удааширсан нь зураг төслийг магадлалаар оруулан хүлээгдэж байгаагаас шалтгаалсан гэж холбогдох байгууллага тайлагнасан байна.

2.12 Био бордооны үйлдвэрийг хувийн хэвшилд тулгуурлан байгуулахаар төлөвлөж Хөгжлийн банкинд хэд хэдэн удаа төсөл хүргүүлсэн боловч зээл олгогдоогүйгээс үйлдвэр баригдаагүй нь хувийн хэвшлийн санаачлагад тулгуурласан бодлогын дэмжлэг үзүүлэх ажил хангалтгүй байгааг харуулж байна.

2.13 Бодит салбарт хэрэгжээгүй арга хэмжээний нөхцөл шалтгааныг тодруулбал:

- 23.1-д заасан “Эрдэнэт, Дархан, Хархорин, Ховд, Улиастай, Зуунмод болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх” ажил барилга, хот

³ Эх сурвалж: Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоол, Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож, авто тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх тухай УИХ-ын мөн оны 36 дугаар тогтоол баталсан

байгуулалтын салбарт 2014 оны улсын төсвийн тухай хуульд хөрөнгө батлагдаагүйгээс хэрэгжээгүй,

- *5.7-д тусгагдсан газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрлэлийг барьж эхлэх ажилд хөрөнгө төлөвлөгдөөгүйн улмаас хэрэгжээгүй,*
- *4.3-т тусгагдсан нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах хүрээнд тусгай замын автобусны дэд бүтцийн барилга барих ажил хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа, зохион байгуулалт муугаас хэрэгжээгүй байна.*

2.14 Бодит салбарт дэвшүүлсэн томоохон зорилт, арга хэмжээний хэрэгжилт хурдац саарсан, үр өгөөж, үр дүн хангалттай биш байгаа нь уул уурхайгаас олох орлого, ашгийн үр дүн гараагүй, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа зэрэг хүчин зүйлээс шалтгаалж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах зорилтод сөргөөр нөлөөлжээ.

Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн зорилт, арга хэмжээнээс “Ногоон хөгжлийн асуудал” бүрэн хэрэгжээгүй байна

2.15 БОНХАЖЯ, НЗДТГ хариуцахаар үндсэн чиглэлд туссан 10 арга хэмжээнээс үндэсний байгаль, соёл, түүхийн өв газруудын хил хязгаарыг тогтоох судалгаа хийж зөвлөмж гарган ногоон хөгжил, ногоон эдийн засгийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийслэлийн гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах зэрэг арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэн байна.

2.16 БОНХАЖЯ аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулан яамдаас санал авч төслийг хүргүүлсэн боловч Засгийн газраас буцаасан нь бодлогын баримт бичгийг үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотойгоор хугацаа алдаж байна.

2.17 Улсын тусгай хамгаалалтад зарим газрыг авах асуудал Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдсэн боловч Засгийн газрын зарим гишүүдийн саналаар тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон байна. Үүнд:

1/ Ховд аймгийн Булган, Алтай сум, Говь-Алтай аймгийн Бугат сумын нутгийн зарим хэсгийг Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн хилийн заагт хамруулан Зүүн гарын говь гэсэн нэр бүхий дархан цаазат газрын ангилалаар;

2/ Ховд аймгийн Булган сумын нутгийн зарим хэсгийг Булган голын эх-Их Онгогийн байгалийн цогцолборт газрын хилийн заагт, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутгийн зарим хэсгийг Дарьгангын байгалийн цогцолборт газрын хилийн заагт тус тус хамруулан байгалийн цогцолборт газрын ангилалаар;

3/ Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нуруу, Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Өлзийт сумдын нутгийг дамнан орших Дулаан хайрхан уулыг байгалийн нөөц газрын ангилалаар тусгай хамгаалалтад авах санал хэлэлцэгдсэн байна.

2.18 Нийслэлд орон нутгийн хөгжлийн сангийн 3,641.6 сая төгрөгийн хөрөнгөөр 15 байршлын 9.93 га талбайд сул шороон хөрсийг хайрган хучилттай болгох, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 3 байршлын 1.63 га талбайд тохижилт, ногоон байгууламж бүхий цэцэрлэг байгуулах 650.4 сая төгрөгийн өртөг бүхий ажил газрын асуудал шийдвэрлэгдээгүйгээс хэрэгжээгүй байна.

2.19 Гэр хорооллын айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулахад 2014 онд 10.0 мянган өрхийг төлөвлөснөөс 3198 айл өрхийг төвлөрсөн шугамд холбох төлөвлөлт, судалгааны ажил эхлэл төдий байна.

2.20 Энэ асуудлыг улсын төсвийн 6,800.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч улсын төсвөөс санхүүжилт аваагүй, харин нийслэлийн төсвөөс 9,441.6 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 8,329.3 сая төгрөг зарцуулсан бөгөөд зорилт, арга хэмжээний биелэлт 69.8 хувьтай байна.

2.21 Байгаль орчин, бүс нутгийн салбарт дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хэрэгжилт 69.0 хувьтай байна.

Нийгмийн хөгжлийн бодлогын 36 зорилт, арга хэмжээний биелэлт 65.0 хувьтай байна

2.22 БСШУЯ, ХАХНХЯ, ХЯ, ЭМСЯ 9 зорилт, 36 арга хэмжээг хариуцан хэрэгжүүлсэн бөгөөд үндсэн чиглэлийн арга хэмжээний 34.6 хувийг нийгмийн салбарын асуудал эзэлсэн байна.

2.23 Гол асуудал нь “Ажилтай, орлоготой монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд, нийгмийн халамжийн бодлогыг зорилтот бүлэг рүү чиглүүлж, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, өрсөлдөх чадварыг сайжруулах, эрүүл мэндийн үйлчилгээг иргэн бүрт хүргэхэд чиглэгдсэн байна.

2.24 Гэхдээ энэ салбарын бодлогын хувьд хүний хөгжлийн асуудал хэрхэн дэмжигдэх нь төлөвлөлтийн болоод хэрэгжилтийн шатандаа тодорхойгүй үлдэж байна.

2.25 ХАХНХЯ-ны хариуцсан арга хэмжээний биелэлт 50.0 хувь, ЭМСЯ-ны арга хэмжээний биелэлт 48.5 хувьтай байгаа нь хариуцсан ажлаа үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилт биелэлтийг хангах талаар санаачлагатай, зохион байгуулалттай ажиллаагүйг харуулж байна.

2.26 Нийгмийн бодлогын салбарт дутуу ба хэрэгжээгүй дараах асуудлууд шийдлээ хүлээж байгаа бөгөөд биелэлтийн байдлыг авч үзвэл:

- 13.2-ын хот суурингаас хөдөө орон нутагт шилжин суурьших, ажил эрхлэх санаачилгыг зээл, санхүүгийн дэмжлэг урамшууллын бодлогоор дэмжих ажил 50 хувьтай;
- 14.1-ийн эх /эцэг/ нь төрүүлсэн хүүхдээ хоёр нас хүртэл, ихэр хүүхдийг гурван нас хүртэл өөрөө асран хүмүүжүүлэх, тэтгэмж дэмжлэгийн эрх зүйн орчныг бүрдүүлэх ажил хийгдээгүй;
- 15.1-ийн төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх ажил 50 хувьтай;
- 19.9-ийн эм ханган нийлүүлэх тогтолцоог бэхжүүлэх ажил 30 хувьтай;
- 19.8-ын эмийн аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх асуудал 30 хувьтай;
- 21.1-ийн багийн спортыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх ажил хэрэгжээгүй;
- 21.2-ын аймаг, нийслэл, сум, дүүрэгт явган аялах чиглэл тогтоож, хөгжүүлэх ажил 10 хувьтай;
- 21.3-ын хүн амыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх ажил хэрэгжээгүй;
- 16.3-ын цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ажлын ачааллыг багасгах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж, 2500 ээлжийн болон туслах багш бэлтгэх арга хэмжээ ажил 10 хувьтай;
- 17.2-ын хүүхэд бүрд ном уншуулах эрмэлзэл төрүүлэх, унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх Цахим сургалтын үндэсний 2 төв байгуулах ажил 30 хувьтай;
- 18.1-ийн монгол судлалын сан байгуулж үйл ажиллагааг нь төрөөс дэмжих арга хэмжээ хэрэгжүүлсэн төсөл, бэлтгэсэн судлаачийн тоо дэвшүүлсэн зорилтод хүрээгүй 30 хувийн биелэлттэй байна.

2.27 Эрүүл мэнд, спортын салбараас биеийн тамир спортын талаар үндсэн чиглэлд тусгагдсан 3 арга хэмжээ хэрэгжээгүй нь хөтөлбөр боловсруулах, аяллын чиглэл тогтоох, хүн амыг чийрэгжүүлэх зэрэг хөрөнгө мөнгө ихээхэн шаардлагатай бус харин удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаагаар хэрэгжих асуудлууд байсан байна.

2.28 Хөдөлмөрийн салбарт түр ажилтныг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг, урамшуулал үзүүлэх арга хэмжээ төлөвлөгдсөн хэмжээнээс 70 хувиар биелжээ.

2.29 Нийгмийн хөгжлийн бодлогын 36 зорилтоос бүрэн хэрэгжсэн 14, дутуу хэрэгжилттэй 18, хэрэгжээгүй 4 асуудал буюу 65.0 хувийн биелэлттэй байна.

Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн зорилт 67.0 хувьтай хэрэгжсэн байна

2.30 Үндсэн чиглэлд төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн чиглэлээр төрийн үйлчилгээ, хүртээмжийг дээшлүүлж, хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилт бүхий 10 арга хэмжээг ХЗЯ, МХЕГ хариуцан хэрэгжүүлсэн байна.

2.31 Аудитаар энэ салбарт тавигдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 67.0 хувьтай үнэлэгдэж бүрэн хэрэгжсэн 4, дутуу хэрэгжсэн 5, хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна.

2.32 Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх асуудалд Монгол Улсын иргэний үнэмлэхийг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээнд ашиглаж ТҮЦ машинаар дамжуулан 23 төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж эхэлсэн боловч уг машины үйл ажиллагааны зардлыг ямар байгууллага хариуцах талаар дүрэм, журам боловсруулах арга хэмжээг зохион байгуулж чадаагүй байна.

2.33 Хууль зүйн салбарын бүх арга хэмжээ үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар үнэлэгдэхээр төлөвлөгдсөн нь дүгнэлт өгөхөд хүндрэлтэй болж, найдваргүй, тодорхойгүй шалгуур үзүүлэлт боловсруулснаас хэрэгжилтэд харьцуулалт хийх боломж хомс байна.

2.34 Хууль сахиулах байгууллагуудыг цахим мэдээллийн сүлжээнд холбох ажлын явц урьдчилсан судалгаа хийж, төслийг боловсруулах шатанд байна.

2.35 Гэмт хэргийн тухай, Мөрдөх албаны тухай зэрэг хууль зүйн салбарын суурь хуулиудын төслийг боловсруулж УИХ-ын холбогдох Байнгын хороонд хүргэгдсэн боловч тайлант хугацаанд хэлэлцэгдээгүйгээс эрх зүйн шинэчлэлийн талаар тавьсан зорилт бүрэн хэрэгжээгүй байна.

Гадаад бодлого, батлан хамгаалах зорилт, арга хэмжээ 58.0 хувьтай хэрэгжсэн байна

2.36 Энэ бодлогын хүрээнд энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулах, батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлэх зорилт бүхий 9 арга хэмжээг ГХЯ, БХЯ хариуцаж бүрэн хэрэгжсэн 1, дутуу хэрэгжсэн 8 арга хэмжээ буюу хэрэгжилт 58.0 хувьтай байна.

2.37 Гадаад харилцааны бодлогын жил бүр дэвшигдэж байгаа дараах арга хэмжээний биелэлт хангалтгүй байна.

- 24.6-ийн манай улстай дипломат харилцаагүй, НҮБ-ын гишүүн улстай дипломат харилцаа тогтоох ажлыг идэвхтэй үргэлжлүүлэх арга хэмжээ 50 хувьтай,
- 24.7-ийн хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, хилийн чанад дахь монгол иргэдийн бүртгэлийн тогтолцоог сайжруулах арга хэмжээ 50 хувьтай,
- 24.3-ын Монголын бараа, бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх арга хэмжээ 50 хувьтай
- 24.4-ийн АНУ-тай стратегийн түншлэл, Канад Улстай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоох чиглэлээр ажиллах арга хэмжээ 50 хувьтай хэрэгжсэн байна

2.38 Аудитаар үндсэн чиглэлийн нийт арга хэмжээнээс зарим ТЕЗ-дын 10 арга хэмжээ хэрэгжээгүй нь дараах шалтгаантай байна. Хавсралт №3-аас үзнэ үү

- **Хөрөнгө, нөөц оновчтой зөв төлөвлөгдөөгүй шалтгаанаар:** ЗТЯ-ны нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах, БХБЯ-ны иргэдийг түрээсийн орон сууцаар хангах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх, АҮЯ-ны газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрийг барьж эхлэх зэрэг асуудлууд хэрэгжээгүй байна
- **Ажлын уялдаа холбоо, удирдлага, зохион байгуулалт сул, бүтээлч санаачлага дутагдсанаас шалтгаалж:** ЭМСЯ-ны Багийн спортыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, аймаг, нийслэл, сум, дүүрэгт явган аялах чиглэл тогтоож явган аялалыг хөгжүүлэх, хүн амыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ачааллыг багасгах, үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, гадаадын зарим орны экспортын болон бусад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ашиглах зэрэг арга хэмжээ байна

2.39 Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан салбар бүрийн зорилт арга хэмжээний хэрэгжилт биелэлтийг хангах талаар зохиосон ажил бодитой үр дүнд төдийлөн хүрээгүй нь ТЕЗ-чид хэрэгжилт, гүйцэтгэлийн үнэлгээг үр дүнд чиглүүлэн хянаж удирдахгүй, зохион байгуулалтаар хангах болон бодлогын дэмжлэг үзүүлэх талаар хангалтгүй, улсын төсөвт шаардлагатай хөрөнгийг төсөвлөж, санхүүжүүлж чадаагүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалсан байна.

Бүлэг 3. ТЕЗ-д үндсэн чиглэлийн биелэлт, гүйцэтгэлийн тайлагналт үр нөлөөтэй болоогүй байна

3.1 ЗГХЭГ-аас үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг яамдаас хагас бүтэн жилээр авч дүгнэж байгаа боловч бүрэн хэрэгжүүлэхэд яамдын ажлын зохион байгуулалтыг сайжруулан удирдах талаар санаачлага багатай ажиллажээ.

3.2 ТЕЗ-д 2014 оны үндсэн чиглэлийн биелэлтийг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын⁴ дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнд чиглүүлэн хийж тайлагнах ажил хангалтгүй, хэрэгжилтийн судалгааг хүргүүлсэн төдийгөөр асуудалд хандаж ЗГХЭГ-т иж бүрэн тайлан ирүүлж байх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй тохиолдол нийтлэг байна.

3.3 ЭМСЯ, УУЯ, ГХЯ, БХЯ, ЗТЯ, ХХААЯ зэрэг яамд тайландаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй, журмаа мөрдөөгүй үндсэн чиглэлийн биелэлт үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн иж бүрэн тайланг ЗГХЭГ болон Сангийн яаманд хүргүүлээгүй дутагдал давтагдсан байна.

3.4 Яамдын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ЭЗХЯ татан буугдаж улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт биелэлтийг нэгтгэн дүгнэх чиг үүрэг Сангийн яаманд шилжсэн бөгөөд арга хэмжээнээс “Гудамж төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх”, “Гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг татаж, бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх” зэрэг арга хэмжээний хэрэгжилт, биелэлтийг хариуцан тайлагнах байгууллага тодорхойгүй байв.

3.5 Сангийн яамнаас улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх “Үндсэн чиглэл”-ийн биелэлтийг 71.0 хувь, ЗГХЭГ “63.7” хувь гэж үнэлжээ:

Хүснэгт №3.1

Бодлогын хамрах хүрээ	Үндсэн чиглэл /тоо/		Үнэлгээ /хувь/		
	зорилт	арга хэмжээ	Сангийн яам	ЗГХЭГ	ҮАГ
I. Макро эдийн засгийн бодлого	1	11	64.0	55.4	52.0
II. Бодит салбарын хөгжлийн бодлого	8	28	68.0	59.2	68.0
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого	3	10	84.0	67.0	69.0
IV. Нийгмийн хөгжлийн бодлого	9	36	74.0	68.8	65.0
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэл	2	10	64.0	61.0	67.0

⁴ МУЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоолын 4-р бүлгийн 18-дах заалт мөрдөнө. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлэх бөгөөд яам нь тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

VI. Гадаад бодлого, батлан хамгаалах	2	9	69.0	66.6	58.0
Дүн	25	104	71.0	63.7	63.2

3.6

Аудитаар үндсэн чиглэлийн 104 арга хэмжээнээс 90-100 хувьтай буюу бүрэн биелсэн 32, 30-70 хувийн биелэлттэй 62, 10 арга хэмжээ хэрэгжээгүй 63.2 хувьтай үнэлэгдлээ. /Дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт № 1, 2, 3 –аас тус тус үзнэ үү/

3.7 Үндсэн чиглэлд тусгагдсан макро түвшний эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл:

Хүснэгт №3.2

Зорилт, арга хэмжээний		Шалгуур үзүүлэлт	Зорилт, арга хэмжээний	
Д.д	Агуулга		хүрэх түвшин	биелэлт
1.1	Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх;	ДНБ-ий бодит өсөлт	14.7	6.9
		1 хүнд ногдох ДНБ	5,300.0 ам.долл	4097.0
1.2	Эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг бууруулах;	Жилийн эцсийн инфляцийн зорилтот түвшин, хувиар	6	11
1.3	Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ төсвийн зохистой харьцааг хадгалах;	ДНБ-д төсвийн тэнцвэржүүлсэн орлогын эзлэх %	35	28.7
		ДНБ-д төсвийн зарлагын эзлэх %	37	32.5
		ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь	2.0	3.7

3.8 Үндсэн чиглэлд хийсэн сүүлийн жилүүдийн судалгаагаар урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг, ДНБ-ий өсөлт болон төсвийн бодлогын зорилт бүрэн хэрэгжээгүй байна.

3.9 Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6,223.4 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр

зээлийн нийт хэмжээ 7,031.4 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 808.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ⁵.

3.10 ДНБ-ий өсөлт 2014 онд 6.9 хувьтай гарсан нь өмнөх оноос буурсан бөгөөд хүрэх түвшнээс 7.8 хувиар бага гарчээ.

- Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4097.0 ам.доллар байгаа нь өмнөх оноос бага зэрэг өссөн боловч зорилтот түвшинд хүрч чадаагүй байна..
- 2014 оны жилийн инфляци өмнөх оны жилийн эцсийн зорилтот түвшнээс 5 пунктээр өссөн байна.
- ДНБ-д нэгдсэн төсвийн алдагдлын эзлэх хувь 2014 онд 3.7 хувьд хүрч зорилтот түвшинг хангаагүй байна.

3.11 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний 2014 оны хэрэгжилтийг өмнөх 3 жилтэй харьцуулбал,

Хүснэгт № 3.2

Үзүүлэлт	2011 он		2012 он		2013 он		2014 он	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хэрэгжсэн	152	32.1	17	29.4	55	11.7	32	30.7
Хэрэгжилт дутуу	305	64.5	120	63.2	101	82.8	62	60.3
Хэрэгжээгүй	16	3.4	8	7.4	10	5.5	10	9.0

⁵ Эх сурвалж: ҮСХ-ны 2014 оны 12 дугаар сарын статистикийн бюллетень 9 дүгээр тал

Эндээс дүгнэж үзэхэд хэрэгжүүлэх арга хэмжээний тоо буурсан боловч хэрэгжилтийн байдалд ахиц дэвшил гараагүй, хэрэгжилт дутуу арга хэмжээний тоо буураагүй зэрэг нь төсвийн зохистой бодлого үгүйлэгдсэн хэвээр байгааг илтгэж байна.

3.12 Сангийн яамны үнэлгээг ҮАГ-аас арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, тайлагналтай харьцуулан авч үзвэл:

Хүснэгт №3.5 /дундаж хувь, тоо/

Хариуцагч	Үнэлгээ		Аудитлагдсан				
	Яамдын өөрийн үнэлгээ	Сангийн яам	Үнэлгээ	Арга хэмжээний тоо	Үүнээс		
					хэрэгжсэн	дутуу	хэрэгжээгүй
АҮЯ	77.5	75.5	52.0	6	-	5	1
БОНХАЖЯ	83.0	81.1	60.5	8	1	7	-
БСШУЯ	88.6	79.4	73.0	17	10	6	1
БХБЯ	86.3	68.7	57.5	7	2	3	2
БХЯ	70.0	70.0	63.0	2	-	2	-
ГХЯ	77.5	75.0	48.7	8	1	6	1
ЗТЯ	90.7	76.7	55.8	5	1	3	1
НЗДТГ	90.0	69.3	65.0	2	1	1	-
СЗХ	80.0	80.0	70.0	1	-	1	-
СЯ	75.0	68.4	68.0	5	1	4	-
УУЯ	68.3	61.7	60.0	10	3	6	1
ХАХНХЯ	68.0	66.0	50.0	4	-	4	-
ХЗЯ	83.3	68.7	70.9	7	3	4	-
ХХААЯ	81.6	71.7	56.0	4	2	2	-
ХЯ	85.0	85.0	65.0	2	1	1	-
ШСАА	100.0	90.0	90.0	1	1	-	-
ЭМСЯ	82.0	70.0	48.5	13	3	7	3
ЭХЯ	81.7	80.7	90.0	2	2	-	-
Дүн	73.3	71.0	63.2	104	32	62	10

3.13 Үндсэн чиглэлийн хэрэгжилт, биелэлтэд ҮАГ-аас хийсэн үнэлгээний дундаж 63.2 хувь болж Сангийн яам, ЗГХЭГ-ын үнэлгээнээс 7.8 пунктээр буурсан байна.

3.14 Үндсэн чиглэлд ТЕЗ-дын дангаар хэрэгжүүлэх 89 арга хэмжээ, толгойлон хэрэгжүүлэх 15 нийт 104 арга хэмжээ батлагдсан бөгөөд хэрэгжсэн 32 буюу 30.7 хувь, хэрэгжилт дутуу 62 буюу 60.3 хувь, хэрэгжээгүй 10 буюу 9.0 хувийг тус тус эзэлж байна.

3.15 Зорилтот түвшинд хүрээгүй болон биелэлт нь хангагдаагүй зорилт, арга хэмжээний шалтгаан, нөхцөл, үр дагаврын хамрах хүрээг тооцож үнэлээгүй, хэрэгжүүлэлтийн явцад гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх талаар ТЕЗ-даас зохиосон ажил хангалтгүй, энэ талаар асуудал дэвшүүлсэн, баримт, нотолгоо гэх зүйл алга байна.

3.16 Үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын хамрах хүрээгээр зорилтуудын хэрэгжилтийн байдлыг авч үзвэл:

Хүснэгт №3.6		/тоо/		
Бодлогын хамрах хүрээ	Хэрэгжилтийн байдал, Үүнээс			
	хэрэгжсэн	хэрэгжилт дутуу	хэрэг-жээгүй	
I. Макро эдийн засгийн бодлого:				
Тоо,	1	8	2	
II. Бодит салбарын хөгжлийн бодлого:				
Тоо,	11	14	3	
III. Байгаль орчин, бүс нутгийн хөгжлийн бодлого:				
Тоо,	1	9	-	
IV. Нийгмийн хөгжлийн бодлого:				
Тоо,	14	18	4	
V. Төрийн үйлчилгээ, засаглал, эрх зүйн шинэчлэлийн бодлого:				
Тоо,	4	5	1	
VI. Гадаад бодлого, батлан хамгаалах:				
Тоо,	1	8	-	
Дүн	32	62	10	

3.17 Эдийн засагт өсөлт саарснаас шалтгаалж зорилтуудын биелэлт хангалтгүй байна.

3.18 Үндсэн чиглэлд тусгагдсан нийгмийн хөгжлийн бодлогын хэрэгжээгүй асуудлын 3 нь спортын салбарыг хөгжүүлэх арга хэмжээ байна. Энэ нь ССАЖЯ-ны /хуучнаар/ хариуцсан арга хэмжээ байгаа бөгөөд тайлагнал байхгүйгээс хангалтгүй хэрэгжсэнд тооцогдсон байна.

3.19 Эдийн засагт хамгийн их нөлөө үзүүлэх бодит салбарын асуудлыг хариуцдаг УУЯ, ЭХЯ, БХБЯ, ХХААЯ зэрэг яамдын хариуцсан арга хэмжээний хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээгээр томоохон зорилт, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй гарч байна.

3.20 Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлтөд давтамжийн хувьд жил бүр дахин дэвшигдсэн эдийн засгийн ач холбогдол бүхий арга хэмжээ батлагддаг ч хүрэх түвшин, үр дүнг сайтар тооцоогүй, нэгдсэн зохион байгуулалт, шуурхай удирдлага, бодлогын дэмжлэг дутмаг байдгаас хэрэгжилт хангалтгүй хэвээр байна. Жишээлбэл:

№	Зорилтын дугаар	Зорилтын агуулга, арга хэмжээ	2011	2012	2013	2014
1	3.2, 3.8	Зэс боловсруулах үйлдвэрийг барьж эхлэх	✓	✓		
2	7.2, 8.2, 2.2	Улаанбаатарт холимог тээврийн ачааны терминал, логистик төв байгуулах		✓	✓	✓
3	3.3, 8.1	Сайншандын аж үйлдвэрийн цогцолборыг барьж эхлэх	✓			✓
4	14.2	Их сургуулийн хотхоныг байгуулах, ажлыг эхлүүлэх, эрчимжүүлэх		✓		✓

Хэрэгжилт, тайлагнал үнэлгээний тогтолцоог шинэ түвшинд гаргах шаардлагатай

3.21 Ихэнх яамд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын шинж чанартай арга хэмжээнд тусгагдсан хөрөнгийг төсөвт тусгагдаагүй шалтгаан, төсөвлөгдсөн хөрөнгөөс төсөвт батлагдсан тухайн арга хэмжээнд зарцуулсан тооцоо, санхүүжилтийн гүйцэтгэлийн талаар тайлагнадаггүй, энэ талаар баримт судалгаа алга байна.

3.22 Зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг нэг бүрчлэн оновчтой тогтоодоггүй, хэрхэн хэмжигдэх нь тодорхойгүй байх, дахин дэвшигдсэн арга хэмжээний суурь болон өөрчлөлтийг хэмжих үзүүлэлтийг тодорхой болгох асуудал хэрэгжихгүй байна.

3.23 Яамдын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, чадавхид чанарын ахиц гарахгүй байгаа нь хэрэгжилтийг тайлагнасан байдлаас ажиглагдаж байгаа бөгөөд үр дүнд чиглүүлэн үнэлгээ хийдэггүй, харгалзах болон дэд шалгуур үзүүлэлтээр баталгаажуулж дүгнэхгүй байна.

3.24 ТЕЗ-чид суурь үзүүлэлтэд тулгуурлан ахиц дэвшлийг тооцдоггүй, үр дүнд суурилсан хяналт- шинжилгээ, үнэлгээ хийдэггүй, найдваргүй, холбиромтгой хэмжүүрээр үр дүн, хүрэх түвшинг үнэлэх дутагдал давтагдаж байгааг анхаарах цаг болсон байна.

Үндсэн чиглэлийн хэрэгжилттэй холбогдуулан гарсан шийдвэрийн биелэлт хангалтгүй байна

3.25 Үндсэн чиглэлийн хэрэгжилт, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн төлөв байдалд сүүлийн 5 жилээр судалгаа хийж үзэхэд холбогдох байгууллага албан тушаалтанд нийтдээ 36 зөвлөмж өгөгдсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. /Хавсралт №4-өөс үзнэ үү/

3.26 ҮАГ-аас 2014 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдалд аудит хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ТЕЗ-чид хангалттай ажиллаагүй бөгөөд төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ажлыг хангалтгүй хэрэгжүүлж ирсэн байна.

3.27 Үндсэн чиглэл болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, түүний тайлагналыг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор⁶ "... бодлогын зорилтууд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын шийдвэр нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг нягтлан тогтоох" гэж заасны дагуу яамд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн баримт бичгээр дамжин хэрэгжиж байгаа төрийн бодлого иргэдийн амьдралд ямар нөлөө үзүүлснийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт болон хэрэглэгчээр үнэлүүлсэн баримт байхгүй байна.

⁶ "Яам болон аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ын 2-т заасан.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Үндсэн чиглэлд зайлшгүй хэрэгцээ шаардлага бүхий зорилт, арга хэмжээг тусгах буюу тэдгээрийг боловсруулах зохистой нэгдсэн арга зүй, стандартыг тогтоож ажиллаагүйгээс төлөвлөлтийн үндэслэл оновчтой болж чадахгүй байна.
- “Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр зайлшгүй шаардлагатай 10 арга хэмжээнд хөрөнгийн эх үүсвэр төлөвлөгдөөгүй бөгөөд төсвийн хуулинд 74.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6 арга хэмжээнд 20.0 тэрбум төгрөг батлагдсан нь хүрэлцэх хэмжээний нөөц болж чадаагүй байна.
- Үндсэн чиглэлд тусгах зорилт, арга хэмжээг анхан шатанд боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхгүй, нэгдсэн удирдамжаар хангадаггүй, төлөвлөлтөд үнэлгээ дүгнэлт өгөхгүй байгаа нь хэрэгжих үндэслэлийг бууруулж байна.
- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөлтөд давтамжийн хувьд жил бүр дахин дэвшигдсэн эдийн засгийн ач холбогдол бүхий арга хэмжээ батлагддаг ч хүрэх түвшин, үр дүнг сайтар тооцоогүй, нэгдсэн зохион байгуулалт, шуурхай удирдлага, бодлогын дэмжлэг дутмаг байдгаас хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.
- Үндсэн чиглэлийн 104 зорилт, арга хэмжээний биелэлтийг тогтоосон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, бодит нөхцөл байдал бусад харгалзах үзүүлэлттэй харьцуулан үнэлж, дүгнэхэд хэрэгжсэн 32, дутуу хэрэгжсэн 62, хэрэгжээгүй 10 арга хэмжээ буюу 63.2 хувийн биелэлттэй гарч эдийн, засаг нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтууд бүрэн биелээгүй байна.
- “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор барих, холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах, стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, шатдаг занараас шатахуун гаргах үйлдвэр байгуулах зэрэг бүтээн байгуулалтын томоохон арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь хөрөнгө төсөв дутагдсанаас гадна, төр, засгийн байгууллагууд нэгдсэн бодлого, зарчмыг мөрдлөг болгохгүй ажил үүргээ хангалттай гүйцэтгэж чадаагүйтэй холбоотой байна.
- Эрүүл мэнд, спортын салбараас биеийн тамир спортын талаар үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээ хэрэгжээгүй нь үндэсний хөтөлбөр боловсруулах, аяллын чиглэл тогтоох, хүн амыг чийрэгжүүлэх зэрэг хөрөнгө мөнгө ихээхэн шаардлагатай бус харин удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаагаар хэрэгжих асуудлууд байсан байна.
- ТЕЗ-д зорилт, арга хэмжээний биелэлтийг үнэлэх, тайлагнахдаа Засгийн газрын баталсан журмаа мөрдлөг болгон ажиллахгүй, ХШҮ-ний нэгжээ үр дүнтэй ажиллуулаагүй нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнд чиглүүлдэггүй дутагдал зарим яамдын хяналт-шинжилгээ үнэлгээний нэгж дээр давтагдсан байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад:

- УИХ-аас үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тайлагнаж байх,
- Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа өмнөх жилийн үндсэн чиглэлийн биелэлт болон он дамжин хэрэгжих зорилт, арга хэмжээг сайтар харгалзан тухайн жилийн үндсэн чиглэлийн төсөлд тодотгол хийх асуудлыг боловсруулж байх,
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаад хэрэгжээгүй асуудалд дүн шинжилгээ хийж 2015 онд бүрэн хэрэгжүүлж, үр дүнг мэдээлэх,
- Эдийн засгийн өсөлтийг хангах гол түлхүүр зорилт, арга хэмжээний биелэлтийг хангах, суурь нөхцлийг бүрдүүлэх зохион байгуулалт, нэгдсэн бодлогын дэмжлэг үзүүлж ажиллах асуудлаар удирдан чиглүүлж, үр дүнг тооцож байх
- Үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний чанарыг сайжруулах, үр дүнд чиглүүлэн хянан удирдах арга хэмжээ авч тайланд зорилт, арга хэмжээний үр дүн, үр нөлөөг тусгаж байх.

Сангийн сайдад:

- Үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээг хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны баримт бичиг, салбар бүрийн эрхэм зорилттой нягт уялдуулан хөрөнгийн эх үүсвэрийн тооцоолол, үндэслэлийг сайтар боловсруулан төлөвлөж байх,
- Үндсэн чиглэлд тусгагдсан, зорилт, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг арга хэмжээ бүрээр тооцдог тогтолцоог бүрдүүлэх,

Төсвийн Ерөнхийлөн захирагч нарт:

- Үндсэн чиглэлийн санал боловсруулах, төлөвлөлтөөс эхлэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрсэн түвшинг үр дагавартай нь харьцуулах, үр дүнгийн хамрах хүрээг тогтоон үнэлж байхаар үнэлгээ, түүний тайлагналыг боловсронгуй болгох,
- Тайлагналд хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг баримтлан ажиллаж, хүний нөөцийн чадавхи, дотоод зохион байгуулалтаа сайжруулан үндсэн чиглэлийн үр дүн, үр нөлөөг тооцож ажиллах,
- Үндсэн чиглэлийн зорилт арга хэмжээний гүйцэтгэлийг тайлагнах, үр дүнг үнэлэх ажлыг журмын дагуу гүйцэтгээгүй холбогдох байгууллага албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах.

Хавсралт 1

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зорилтын дугаар	Зорилт, арга хэмжээний агуулга	Хариуцан хэрэгжүүлэгч
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
1	1.3	Гадаад зах зээлээс хямд эх үүсвэрийг татаж, бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх	ЗТ, БХБЯ, Монгол банк
ХОЕР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
2	3.1	Олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлэх	ЗТЯ
3	4.2	“Гудамж” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	ЭЗХЯ, ЗТЯ
4	4.4	ОХУ, БНХАУ-ыг холбосон төмөр зам, авто зам, нефть, байгалийн хий, эрчим хүчний дэд бүтцийн урсгалыг бий болгох бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах	ЭЗХЯ, ЗТЯ, ЭХЯ
5	5.2	Эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих	УУЯ
6	5.3	Газрын тосны тухай, Ашигт малтмалын тухай хуулиудыг шинэчлэн боловсруулах,	УУЯ
7	6.1	Эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх	ЭХЯ
8	6.2	Гэр хорооллын цахилгаан хангамжийг найдвартай болгох	ЭХЯ
9	7.1	Барилгын материалын импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	БХБЯ, ЭЗХЯ, ҮХААЯ, ХЯ
10	7.2	Барилгын төлөвлөлтийн норм, дүрэм, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөн боловсруулах	БХБЯ, ХЗЯ
11	8.2	Арьс шир, ноос, ноолуур, оёмол, сүлжмэл, мах сүүний чиглэлийн боловсруулах аж үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжин хөгжүүлэх	ҮХААЯ
12	8.5	Үр тариа болон жимс, жимсгэний ургацыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх	ҮХААЯ
ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
13	10.4	Европын холбооны болон олон улсын (ISO) шинэ дэвшилтэт стандарт, норм нормативыг нэвтрүүлэх	БОНХЯ
ДӨРӨВ.НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
14	13.3	Цалин хөлсний бодлогыг шинэчлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	ХЯ
15	16.1	Боловсролын байгууллагын олон улсын солилцооны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	БСШУЯ
16	16.2	Олон улсын жишигт нийцсэн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, арга зүй, технологийн шинэчлэл хийх	БСШУЯ
17	16.4	Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй технологийг багшид эзэмшүүлэх "Багшийн хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БСШУЯ
18	16.5	Инженерийн боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлж, олон улсын загварыг турших	БСШУЯ
19	16.7	“Өрсөлдөх чадвартай Монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлэх, дэлхийн шилдэг сургуулиудад оюутан сургах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх	БСШУЯ

20	17.4	Насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлж, олон нийтийн хандлага, төлөвшлийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх	БСШУЯ
21	17.6	Их сургуулиудын хотхон байгуулах чиглэлээр ажиллах	БСШУЯ
22	17.7	Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг хөгжүүлэх	БСШУЯ
23	19.6	Уламжлалт эмийн түүхий эдийн стандартыг боловсронгуй болгох	ЭМСЯ
24	19.7	Эмийн чанарыг баталгаажуулах стандартыг боловсруулах	ЭМСЯ
25	19.10	“Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	ЭМСЯ
26	20.1	Хөдөө орон нутгийн соёлын төвүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих	БСШУЯ, ССАЖЯ
27	20.2	Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	БСШУЯ, ССАЖЯ
ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ			
28	22.1	Төрийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэтгэж, цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх	ХЗЯ
29	22.2	Эрүүгийн бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх	ХЗЯ
30	22.5	Хилийн шалган нэвтрүүлэх тогтолцоог шинэчлэх	ХЗЯ
31	22.8	Хилийн боомт дахь хяналт шалгалтыг эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүнд чиглүүлж, аюулгүйн үзүүлэлтэд суурилсан хяналт, шинжилгээг өргөжүүлэх	ХЗЯ, МХЕГ
ЗУРГАА.ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ			
32	24.2	Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах	ЭЗХЯ

Хавсралт 2

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зорилтын дугаар	Зорилт, арга хэмжээний агуулга	Хариуцан хэрэгжүүлэгч
НЭГ.МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
1	1.1	Эдийн засгийн өндөр өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх	ЭЗХЯ
2	1.2	Эдийн засгийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг бууруулах Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ЭЗХЯ, УУЯ
		Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ҮХААЯ, ЗТЯ, БХБЯ
3	1.4	Баялгийн сангийн тогтолцоог Монгол Улсад бий болгон хөгжүүлэх	СЯ
4	1.5	Нийгмийн даатгалын санг мөнгөжүүлэх замаар ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг эхлэх	ЭЗХЯ, БХБЯ, ХАХНХЯ,
5	1.7	Гадаад худалдааны гол түнш улсуудтай тухайн улсын валютаар арилжаа хийх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллах	ЭЗХЯ
6	1.8	Төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлж, орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, төсвийн зохистой харьцааг хадгалах	СЯ
7	1.9	Үнэ, тарифын тухай хуулийг шинээр боловсруулж, хэрэгжүүлэх	ЭЗХЯ
8	1.10	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	СЗХ
ХОЕР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
9	2.1	Төмөр замын суурь бүтцийг барих бодлогыг хэрэгжүүлэх	ЗТЯ
10	2.2	Холимог тээврийн ачааны нэгдсэн терминал, логистикийн төв байгуулах бодлого хэрэгжүүлэх	ЗТЯ
11	4.1	Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлэх	ЗТЯ
12	5.1	Геологийн албыг бэхжүүлж, геологийн судалгааг өргөжүүлэх	УУЯ
13	5.4	Стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийж, нөөцийг тогтоосон зарим ордыг стратегийн ач холбогдол бүхий ордод хамруулах	УУЯ
14	5.5	Шатдаг занарын эрэл хайгуулыг идэвхжүүлж, шатдаг занараас шатахуун гаргах үйлдвэр, туршилтын ажлыг эхлүүлэх	УУЯ
15	5.6	Эзэнгүй, эвдрэлтэй талбайг нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлэх	УУЯ
16	5.8	Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор улсын шатахууны нөөц хадгалах агуулахыг байгуулах	УУЯ
17	5.9	Хийн түлшний үйлдвэрлэлийг хөгжүүлж, холбогдох норм, стандартыг шинэчлэн боловсруулах	УУЯ

18	8.1	“Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх	АҮЯ, ҮХААЯ, ЭЗХЯ
19	8.3	Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	ҮХААЯ
20	8.4	Био бордооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	ҮХААЯ
21	9.1	Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх “Аялал жуулчлал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БОНХАЖЯ, ССАЖЯ
22	9.2	Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх	БОНХАЖЯ, ССАЖЯ
ГУРАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
23	10.1	Иргэн, аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг дэмжиж, ногоон эдийн засгийн хөгжлийн орчныг бүрдүүлэх чиглэлээр татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох	БОНХАЖЯ
24	10.2	Үндэсний байгаль, соёл, түүхийн өв газруудын хил хязгаарыг тогтоох	БОНХАЖЯ
25	10.3	Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах	НЗДТГ
26	10.5	“Саарал” усыг эргүүлэн ашиглахтай холбогдсон норм, стандартыг батлуулах	БХБЯ, БОНХЯ
27	11.1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх	БОНХАЖЯ
28	11.2	Уур амьсгалын өөрчлөлтөд өртөх нэн ховор, ховордсон амьтдын эрсдэлийн үнэлгээ хийх, сэргээн нутагшуулах, үржүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БОНХАЖЯ
29	11.3	Устах аюулд орж байгаа ургамлыг хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, нэн ховор, ховор ургамлыг тарималжуулах, генофондыг бий болгох	БОНХАЖЯ
30	12.1	Аймгийн төвүүдийг хөгжүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	БХБЯ, ЭЗХЯ, СЯ, ЭХЯ
31	12.2	“Сум” төслийг хэрэгжүүлж эхлэх	АҮЯ, ЭЗХЯ
ДӨРӨВ.НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
32	13.1	Түр ажилтныг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг, урамшуулал олгох	ХЯ
33	13.2	Хот, суурингаас хөдөө орон нутагт шилжин суурьших, ажил эрхлэх санаачилгыг зээл, санхүүгийн дэмжлэг, урамшууллын бодлогоор дэмжих	АҮЯ,ХЯ, ЭЗХЯ
34	14.1	Эх /эцэг/ нь төрүүлсэн хүүхдээ хоёр нас хүртэл, ихэр хүүхдийг гурван нас хүртэл өөрөө асран хүмүүжүүлэх тэтгэмж, дэмжлэгийн эрх зүйн орчныг бий болгох	ХАХНХЯ, СЯ
35	15.1	Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчлэх	ХАХНХЯ
36	15.2	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус салбарт ажиллагчдад зориулсан тэтгэврийн даатгалын тусгай сан, хөтөлбөрийг бий болгох	ХАХНХЯ
37	16.6	Багш, инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	БСШУЯ
38	17.1	Хүүхэд бүрийг авьяаст нь тулгуурлан хөгжүүлэх “Авьяас” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БСШУЯ
39	17.2	Хүүхэд бүрд ном уншуулах эрмэлзэл төрүүлэх, унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	БСШУЯ

40	17.3	Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг тогтолцооны хэв шинжид оруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, үнэлгээг сайжруулж, багшлах боловсон хүчнийг бэлтгэн мэргэшүүлж, давтан сургаж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгох	БСШУЯ
41	17.5	Техник, технологийн чиглэлээр Монгол-Германы хамтарсан дээд сургууль байгуулах ажлыг эхлүүлэх	БСШУЯ
42	18.1	Монгол судлалын сан байгуулж үйл ажиллагааг нь төрөөс тусгайлан дэмжих	БСШУЯ
43	19.1	Эрүүл мэндийн салбарын ажилтны хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх	ЭМСЯ
44	19.2	Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг өргөжүүлэх	ЭМСЯ, ХАХНХЯ
45	19.3	Эрүүл мэндийн технологийн нэгдсэн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх	ЭМСЯ
46	19.4	Эмнэлгийн яаралтай тусламжийн хүрээг өргөтгөх	ЭМСЯ
47	19.5	Нийгмийн халамж, дэмжлэг шаардлагатай иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	ЭМСЯ
48	19.8	Эмийн аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлж, импортын болон дотоодын үйлдвэрлэгчдийн эмийн худалдаанд хяналт тавих	ЭМСЯ
49	19.9	Эм ханган нийлүүлэх тогтолцоог бэхжүүлэх	ЭМСЯ
ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ			
50	22.3	Хорих байгууллагын тогтолцоог шинэчлэх	ХЗЯ
51	22.4	“Улсын хил хамгаалалтын техник хангамжийг сайжруулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	ХЗЯ
52	22.6	Хуулийн боловсролын шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ХЗЯ
53	22.7	Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын цахим мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх	ХЗЯ
54	23.2	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийх	БХБЯ, БСШУЯ, СЯ, ОБЕГ
ЗУРГАА.ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ			
55	24.1	Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	АҮЯ, ЭЗХЯ
56	24.3	Монголын бараа, бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх	ГХЯ, Холбогдох яам
57	24.4	АНУ-тай стратегийн түншлэл, Канад Улстай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоох чиглэлээр ажиллах	ГХЯ
58	24.5	Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төвийг үүсгэн байгуулах олон улсын хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгож, үйл ажиллагааг эхлүүлэх	ГХЯ
59	24.6	Манай улстай дипломат харилцаагүй, НҮБ-ын гишүүн улстай дипломат харилцаа тогтоох ажлыг идэвхтэй үргэлжлүүлэх	ГХЯ
60	24.7	Хилийн чанадад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, хилийн чанад дахь монгол иргэдийн бүртгэлийн тогтолцоог сайжруулах	ГХЯ

61	25.1	Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр төслүүдийг хэрэгжүүлэх	БХЯ
62	25.2	"Мэргэжлийн анги, байгууллагыг бүсчлэн байгуулах" төслийн хүрээнд улсын хэмжээний бүтээн байгуулалтын ажилд оролцох ангиудыг бүсчлэн байгуулж эхлэх;	БХЯ

Хавсралт 3

ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖЭЭГҮЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зорилтын дугаар	Зорилт, арга хэмжээний агуулга	Хариуцан хэрэгжүүлэгч
НЭГ.МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО			
1	1.6	Гадаадын зарим орны экспортын болон бусад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг ашиглах	УУЯ, ЭЗХЯ, ГХЯ,
2	1.11	Банк, санхүү, бирж, мэдээллийн технологи, амралт цэнгээний болон агаарын замын зангилаа төв байгуулах чиглэлээр ажиллах	ЭЗХЯ
ХОЁР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
3	4.3	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах	ЗТЯ
4	5.7	Газрын тос боловсруулах дотоодын үйлдвэрийг барьж эхлэх	УУЯ
5	7.3	Иргэдийг түрээсийн орон сууцаар хангах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	БХБЯ, СЯ, НЗДТГ
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО			
6	16.3	Цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшийн ажлын ачааллыг багасгах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	БСШУЯ
7	21.1	Багийн спортыг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;	ЭМСЯ
8	21.2	Аймаг, нийслэл, сум, дүүрэгт явган аялах чиглэл тогтоож, явган аяллыг хөгжүүлэх;	ЭМСЯ
9	21.3	Хүн амыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх	ЭМСЯ
ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ			
10	23.1	Эрдэнэт, Дархан, Хархорин, Ховд, Улиастай, Зуунмод болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх	БХБЯ, АНЗДТ, ТББ

[illegible]

